



НИЙСЛЭЛИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 976  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нийслэлийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Нийслэлийн Монгол Ардын намын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр /.....<sup>16</sup> хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРОО

# ХОТЫН СЭРГЭЛТ 20 МИНУТЫН ХОТ


Нийслэлийн Монгол Ардын Намын 2024 оны  
ННТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

УЛААНБААТАР ХОТ  
2024 ОН





<b>1. БИДНИЙ ХОТ</b>	2
1.1. Иргэдийн оролцоотой хот төлөвлөлт	2
1.2. Дэд төвүүдийн хөгжил	2
1.3. Орон сууцны хүртээмж	3
1.4. Эрчим хүч, дулааны бие даасан байдал	4
1.5. Ус хангамж, ариутгах татуурга	4
<b>2. ХҮРТЭЭМЖТЭЙ ХОТ</b>	5
2.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж	5
2.2. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж	5
2.3. Хүний хөгжил, нийгмийн хамгаалал	6
2.4. Олон төрөлт нийтийн тээвэр	7
2.5. Авто замын хүртээмж	7
<b>3. НОГООН ХОТ</b>	8
3.1. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал	8
3.2. Ногоон байгууламж	9
3.3. Агаар, хөрс, дуу чимээний бохирдол	9
3.4. Хог хаягдлын менежмент	10
<b>4. ОРЛОГОТОЙ ХОТ</b>	10
4.1. Хувийн хэвшлийг дэмжинэ	10
4.2. Нийслэлийн өмчийн зөв менежмент	11
4.3. Хотын соёл, спорт урлаг, аялал жуулчлал	11
4.4. Дагуул хот ба аж үйлдвэрийн парк	12
<b>5. АЮУЛГҮЙ ХОТ</b>	12
5.1. Хүрээлэн буй орчны оновчтой төлөвлөлт	12
5.2. Инновац, хиймэл оюун ухаан, цахим үйлчилгээ	13
5.3. Гамшгийн бэлэн байдал	13



# ХОТЫН СЭРГЭЛТ - 20 МИНУТЫН ХОТ



## 1. БИДНИЙ ХОТ

### 1.1. Иргэдийн оролцоотой хот төлөвлөлт


- 1.1.1. Хотын даргыг иргэд шууд сонгодог болж, үйл ажиллагааны тайланг жил бүр олон нийтээр ил тод, нээлттэй хэлэлцүүлдэг болгоно.
- 1.1.2. Эрх мэдэл, төсөв санхүүгийн хувьд нэгдсэн удирдлагаас хамааралтай байсан 6 дүүрэг, 204 хороодыг 14 хот 42 хороолол болгон төрийн үйлчилгээг иргэндээ ойртуулна.
- 1.1.3. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Иргэний ая тухтай, аж төрөх боломжийг нэмэгдүүлж, иргэд өөрийн гэрээс 20 минутын зайд өдөр тутмын хэрэгцээт нийгмийн суурь үйлчилгээг шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.5. Иргэд хотынхоо ойрын болон хэтийн төлөвлөлтөд оролцох боломжийг бүрдүүлж, бичил болон жижиг төслүүдийг оршин суугчид хэрэгжүүлэх боломж бололцоог нээнэ.
- 1.1.6. Төлөвлөлтөд тулгуурласан төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн уялдааг бэхжүүлнэ.
- 1.1.7. Төлөвлөлтийн бус барилгажилтын золиос болсон орон сууцны хотхон, хорооллыг дахин шинэчилж, авто зогсоол, ногоон байгууламж, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.8. Зохицуулалтын алдаатай шийдвэрээс үүдэлтэй тусгай хамгаалалттай газар бий болсон суурьшлын бүсийг цэгцлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.1.9. Иргэд хувийн хэвшлийн оролцоотойгоор автомашингүй гудамжийг бий болгож, автомашингүй өдрийн тоог нэмнэ.
- 1.1.10. Худалдаа, үйлчилгээ, соёл урлаг, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг байгуулж, нэгдсэн загварыг оршин суугчдын оролцоотойгоор гаргаж мөрдүүлнэ.

### 1.2. Дэд төвүүдийн хөгжил

- 1.2.1. Хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлыг бууруулах хүрээнд амьдрах орчин, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, бизнесийн боломжийг нэгдсэн байдлаар төлөвлөсөн дэд төвүүдийг хөгжүүлнэ.

Үүнд:

- 1.2.1.1. Баянхошуу-Ханын материал дэд төв
- 1.2.1.2. Сонгинохайрхан дэд төв
- 1.2.1.3. Толгойт дэд төв
- 1.2.1.4. Сэлбэ дэд төв






- 1.2.1.5. Дамбадаржаа дэд төв
- 1.2.1.6. Дэнжийн мянга дэд төв
- 1.2.1.7. Шархад дэд төв
- 1.2.1.8. Амгалан дэд төв
- 1.2.1.9. Дарь-Эх дэд төв
- 1.2.1.10. Яармаг дэд төв
- 1.2.2. Дэд төвүүдэд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн төрийн болон нийгмийн цогц үйлчилгээг хүртээмжтэй авах боломжтой нэгдсэн төлөвлөлт бүхий 40,000 айлын орон сууцны цогцолбор хорооллыг барьж ашиглалтад оруулна.
- 1.2.3. Дэд төвд их дээд сургууль, худалдаа, үйлчилгээ, томоохон хүнсний зах, агуулах, худалдааны төв, соёл, урлаг, спортын цогцолбор, зорчигч тээврийн төвүүдийг бүтээн байгуулах, шилжүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 1.2.4. Дэд төвд орон сууц барьсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх бодлого баримтална.

### 1.3. Орон сууцны хүртээмж

- 1.3.1. "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.3.2. "Миний ажилтан орон сууцтай" хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид болон ажилтандаа орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлсэн хувийн хэвшлийн ААН-үүдэд хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.3.3. Ипотекийн зээлийн 50-аас багагүй хувийг Улаанбаатар хотын дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно.
- 1.3.4. "Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц төсөл"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.5. Пассив, хайбрид байшинд шилжих хүсэлтэй өрх, аж ахуйн нэгжид ногоон орон сууцны зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.6. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэх, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 1.3.7. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барина.
- 1.3.8. Нийтийн орон сууцны хэрэглэгчдийн халаалтын төлбөрийг талбайн хэмжээгээр биш дулааны тоолуур ашиглан бодит хэрэглээгээр нь тооцох зохицуулалтыг нэвтрүүлнэ.



#### 1.4. Эрчим хүч, дулааны бие даасан байдал

- 1.4.1. Эрчим хүч, дулааны төвлөрсөн эх үүсвэрийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил, тархмал эх үүсвэрийн ажлыг эрчимжүүлж, үнийн тарифыг чөлөөлж, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих бодлого баримталж, найдвартай, аюулгүй байдлыг хангана.
  - 1.4.1.1. Дулааны II, III цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөн шинэчилнэ.
  - 1.4.1.2. Багануурын 400 МВт-ын цахилгаан станцыг барина.
  - 1.4.1.3. Эмээлт эко аж үйлдвэрийн паркт 25 МВт-ын дулааны цахилгаан станцыг барьж байгуулна.
  - 1.4.1.4. Бие даасан, тархмал дулааны эх үүсвэрээр дулаан хангамжийн суурилагдсан хүчин чадлыг 595 МВт-аар нэмэгдүүлнэ.
  - 1.4.1.5. Бөөрөлжүүтийн ордыг түшиглэсэн 600 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станцыг үе шаттайгаар ашиглалтад оруулна.
  - 1.4.1.6. 50 МВт буюу 200 МВт/цаг баттерей хураагуурын станцыг барьж оргил цагийн ачааллыг бууруулна.
  - 1.4.1.7. Угсармал орон сууцнуудад дулаан техникийн шинэчлэлийн төсөл хэрэгжүүлэн дулаан алдагдлыг бууруулах замаар эрчим хүчийг хэмнэнэ.
  - 1.4.1.8. Байгалийн хийгээр ажиллах дулааны эх үүсвэрүүдийг барих, уурын зуухуудыг хийн хэрэглээ рүү шилжүүлэх зэрэг нүүрсний хэрэглээг байгалийн хийн хэрэглээрүү үе шаттайгаар шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 1.4.2. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ
  - 1.4.2.1. Ногоон зээлийн санхүүжилтээр олон улсын байгууллагатай хамтран хашаа бүрд өрхийн нарны панел цахилгаан хураагуур, халаалтын системийн тогтолцоог бий болгох, байшин, гэр хорооллын дулаалга, дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.
  - 1.4.2.2. Өрх бүр өөрийн илүүдэл эрчим хүчний төвийн эрчим хүчинд нийлүүлэх түүнчлэн бууруулсан хүлэмжийн хийн хэмжээгээр нүүрсхүчлийн хийн кредитийн олон улсын зах зээлээс санхүүжилт авах эрх зүй болон санхүүжилтийн механизмыг бий болгоно.

#### 1.5. Ус хангамж, ариутгах татуурга

- 1.5.1. Туул усан цогцолбор төслийг хэрэгжүүлэн ундны усны баталгааг хангана.
- 1.5.2. Төвлөрөл ихтэй хэсгийн шугам сүлжээг туннеллийн системд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.
- 1.5.3. Туул-1 коллекторын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.
- 1.5.4. Дэд төвүүдэд хэсэгчилсэн ариутгах татуургыг төр хувийн хэвшлийн түншлэлтэйгээр барьж байгуулна.
- 1.5.5. Эмээлт эко аж үйлдвэрийн паркт олон улсын стандартад нийцсэн цэвэрлэх байгууламжийг барьж байгуулна.

1117 1456  
УХА0612 30/1270

- 1.5.6. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн буюу саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
- 1.5.7. Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, инженерийн шугам сүлжээний арчлалт, өргөтгөл шинэчлэлт, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар дэд бүтцийн санг байгуулна.


## 2. ХҮРТЭЭМЖТЭЙ ХОТ

### 2.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж

- 2.1.1. 2-5 насны хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулахыг зорьж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд байлгана.
- 2.1.2. Хүүхэд өнжүүлэх болон хөгжлийн төвийг хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулна.
- 2.1.3. Цэцэрлэгийн хоол болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолны стандартыг шинэчлэн, илчлэгт анхаарч, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.
- 2.1.3.1. “Сүү” хөтөлбөрийг хамтын санхүүжилтээр дэмжиж, цар хүрээг нэмэгдүүлнэ.
- 2.1.3.2. Сургууль, цэцэрлэгийн хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог хуульд нийцүүлэн нэгдсэн хангамжийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 2.1.3.3. Улаанбаатар хотод хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний хяналт, баталгаажуулалтыг бэхжүүлэх хүрээнд хяналтын лаборатори шинээр байгуулна.
- 2.1.4. Ерөнхий боловсролын сургуулиудад шүдний кабинет байгуулж, “Эрүүл шүд” хөтөлбөрийг эрчимжүүлнэ.
- 2.1.5. Ерөнхий боловсролын сургуулийн хэрэгцээ өндөртэй байгаа гэр хорооллын 52 байршилд хүн амын нягтаршил, өсөлт, хүртээмжийг үндэслэн гэрт хамгийн ойр сургууль барих ажлыг шат дараатай хэрэгжүүлж, амьдарч буй орчиндоо чанартай боловсролын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.1.6. Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлтийг стандартад ойртуулан, багш нарын ачааллыг бууруулах урамшууллын зохицуулалтыг хийнэ.
- 2.1.7. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хотын соёл, эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийн боловсруулж, хэрэгжүүлнэ.

### 2.2. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

- 2.2.1. Шинээр байгуулах 14 хотод 20 минутын зайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 2.2.2. “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.
- 2.2.3. Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.



A handwritten signature in black ink, consisting of a stylized, cursive script.



- 2.2.4. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвүүдийг байгуулна.
- 2.2.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулна.

### **2.3. Хүний хөгжил, нийгмийн хамгаалал**

- 2.3.1. Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2. Хүүхэд**
- 2.3.2.1. Улаанбаатар хот орчмын ногоон бүсэд байгаа хүүхдийн зусланг төрөлжсөн хөтөлбөртэй болгож, зуны болон өвлийн амралтаа бүтээлч байдлаар өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.2.2. Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг хангуулж, арчлалт үйлчилгээг оршин суугчдын оролцоотойгоор тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангана.
- 2.3.2.3. Сургуулийн боловсролын хөтөлбөрт эрүүл мэнд, хог хаягдал, байгаль орчин, ажил мэргэжил, замын аюулгүй байдлын талаар салбарын мэргэжилтний хичээлийг нэвтрүүлнэ.
- 2.3.3. Залуучууд**
- 2.3.3.1. Төв цэнгэлдэх хүрээлэнг 4 улирлын турш ашиглах боломжтой, орчин үеийн спорт цогцолбор, амралт чөлөөт цагийн төв болгон хөгжүүлж, залуучуудын спорт, соёлын арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.3.2. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх инкубатор төвийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.
- 2.3.3.3. Хүүхэд залуучуудын согтууруулах ундаа, тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.3.3.4. Шинэ тутам хөгжиж байгаа цахим спортын арга хэмжээг зохион байгуулна.
- 2.3.4. Гэр бүл**
- 2.3.4.1. 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулах, цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийн зохицуулалтыг хийх замаар эцэг, эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.4.2. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд “Аав, эрчүүд”, “Чанартай амьдрал-аавуудын оролцоо” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.3.4.3. Хүртээмжтэй үйлчилгээний төвүүдийг оршин суугчдын хэрэгцээнд тулгуурлан шинэчлэн сэргээнэ.

11171456  
УХА0612 9077278

### 2.3.5. Ахмадууд


- 2.3.5.1. Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцсэн байдлаар зохион байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 2.3.5.2. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг шинээр тавих гудамж, зам, нийтийн тээвэр болон төрийн байгууллагуудад мөрдүүлнэ.
- 2.3.7. Нийслэлийн төрийн албан хаагчдыг цахимаар, зайнаас, гэрээс ажиллах ажил эрхлэлтийн уян хатан зохицуулалтыг өргөжүүлнэ.

### 2.4. Олон төрөлт нийтийн тээвэр

- 2.4.1. Олон төрөлт нийтийн тээврийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулна.
  - 2.4.1.1. Метроны бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.
  - 2.4.1.2. Тусгай замын автобус (BRT)-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. Агаарын дүүжин замын тээврийг нэвтрүүлж, зориулалтын зогсоол, дэд бүтцийг байгуулна.
  - 2.4.1.3. Нийтийн тээврийн автобусны үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчилж, эрэлтэд тулгуурлан хүртээмжтэй байдлаар шийднэ.
  - 2.4.1.4. Гэр хорооллын нийтийн тээврийн хүртээмжгүй бүсэд 16 чиглэлийн дунд оврын автобусны үйлчилгээ, автобусны буудлуудыг ашиглалттай болгох ажлыг хувийн хэвшилтэй хамтран эхлүүлнэ.
- 2.4.2. Цэвэр, аюулгүй, мэргэшсэн жолооч бүхий Улаанбаатар хотын такси үйлчилгээний стандартыг бий болгоно.
- 2.4.3. Нийтийн тээврийн удирдлага, мэдээлэл, хяналтын ухаалаг системийг зорчигчдын эрчимжилтэд тулгуурлан ажилладаг байдлаар зохицуулна.

### 2.5. Авто замын хүртээмж

- 2.5.1. Улаанбаатар хотод шинэ тойрог замын сүлжээг үе шаттайгаар хөгжүүлж, дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн тоог бууруулан түгжрэлийг багасгана.
- 2.5.2. Туулын хурдны зам болон Сэлбэ сэргэлт замыг үе шаттайгаар барьж байгуулна.
- 2.5.3. Хотын төвд 55 км дугуйн замын маршрутыг явган болон ногоон байгууламжтай хамт төлөвлөж, бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- 2.5.4. Их тойруугийн Баруун болон Зүүн 4 зам, Нарантуул, 32 тойргийн уулзвар болон Саппорогийн уулзваруудыг давхар болгох ажлыг эхлүүлнэ.



A handwritten signature in black ink, consisting of stylized cursive letters.

- 2.5.5. Улаанбаатар хотын авто замын үндсэн сүлжээг хөгжүүлж, гол, туслах гудамж замыг шинээр барьж, Нарны замын зүүн өргөтгөл, Өнөр хорооллын гудамж, Улаанхуарангийн гудамж, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Чингэлтэйн өргөн чөлөө, Яармагийн шинэ замыг өргөтгөн шинэчилнэ.
- 2.5.6. Улаанбаатар хотод “бүрэн гудамж” стандартыг нэвтрүүлнэ.
- 2.5.7. Туулын авто замыг нисэхийн хурдны автозамтай холбох “Наадамчдын гүүр” төслийг хэрэгжүүлнэ.
- 2.5.8. Өөдөө тэмүүлэх Монгол “Гөү-Монголиа” гүүрийг шинэ тойрог замтай холбон Туул гол дээгүүр бүтээн байгуулна.
- 2.5.9. Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд газар дээрх, газар доорх, автомат олон давхар, их багтаамжийн зэрэг бүх төрлийн авто зогсоолыг хувийн хэвшилтэй хамтран хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулах “Авто зогсоол хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

### 3. НОГООН ХОТ

#### 3.1. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал

- 3.1.1. “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, чанарын хяналт удирдлагын тогтолцоог сайжруулж, гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 3.1.2. Бүсчилсэн хөгжлийн бодлого, Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд Улаанбаатар хотын иргэдийг хямд чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.3. Загас, загасан бүтээгдэхүүнийг хүнсний хэрэглээний бүтцэд оруулж, нийлүүлэлтийг дотоодоос бий болгох боломжийг хувийн хэвшилтэй хамтран бүрдүүлнэ.
- 3.1.4. Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг дэмжиж, хотын хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.5. Сүү, цагаан идээ үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр дагуул хотуудад хөгжүүлж, нэмэгдэл уураг, уургийн бэлдмэл зэрэг бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжийг бүрдүүлнэ.
- 3.1.6. Эрчимжсэн аж ахуй эрхлэх зориулалттай бүс нутгийн хил заагийг тогтоож хөдөө аж ахуйн төрөлжсөн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд хувийн хэвшлийг дэмжинэ.
- 3.1.7. Хүнс, нарийн ногоо, жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалтын цогцолбор төвүүдэд нийт 50,000 тн багтаамжтай агуулахыг барьж байгуулан хотыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах тогтолцоог анхаарч, төр хувийн түншлэлээр шийднэ.
- 3.1.8. Мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах орчин үеийн стандартын шаардлага хангасан цогцолборыг Эмээлт болон Налайхад

1117145633  
УХА0612 9077278

байгуулж, суурьшлын бүсэд амьд мал оруулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх арга хэмжээг авна.




### 3.2. Ногоон байгууламж

- 3.2.1. Хотын ногоон байгууламжийг төрөлжүүлж, иргэд оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах ногоон байгууламж, цэцэрлэгтэй болох боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.2. Улаанбаатар хотын ойр орчимд хөв цөөрөм байгуулж, байгалийн нөхөн сэргээлтийг бүрдүүлэхээс гадна иргэдийн ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлнэ. Уг ажлыг хэрэгжүүлэх хувийн хэвшлийг дэмжинэ.
- 3.2.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, “Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-тэй уялдуулан 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.2.4. Айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг урамшуулан, мод ургуулах дадлыг бий болгох арга замаар дэмжиж ажиллана.
- 3.2.5. Туул, Сэлбэ, Улиастай, Наран, Дунд голын эргийн дагуу, дэд төвүүдэд иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчин, уул толгодтой холбогдсон хотын ногоон сүлжээ, дугуйн болон гүйлтийн замын холболтын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эхлүүлнэ.
- 3.2.6. Төвлөрсөн дэд бүтцээс алслагдсан гэр хорооллын бүсэд гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлсэн, эрчим хүчний хэмнэлт бүхий ногоон “Нийтийн ахуйн үйлчилгээний төсөл”-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 3.2.7. Барилга байгууламжийн дээврийн хур борооны усыг цуглуулах технологийн шийдлийг дэмжиж, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн хэрэгцээ, ногоон байгууламжийн усалгааны хэрэглээг хэвшүүлнэ.

### 3.3. Агаар, хөрс, дуу чимээний бохирдол

- 3.3.1. Ундны усны шугамыг зэс хоолойгоор солих судалгаа хийж, усны зэвийг арилгах зорилгоор цэвэр усны шугамыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.
- 3.3.2. Харгиа цэвэрлэх байгууламжийг Эмээлт аж үйлдвэрийн парк руу нүүлгэн шилжүүлж, хөрсний нөхөн сэргээлтийг хийнэ.
- 3.3.3. Гэр хорооллыг орон сууцжуулах, цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах замаар нүхэн жорлонгийн тоог бууруулж, хөрсний бохирдлыг бууруулах стандарт, нөхөн сэргээх, ногоон байгууламжуудыг бий болгох ажлыг иргэдийн оролцоотойгоор цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.



- 3.3.4. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа уурын зуухны технологийн шинэчлэлийг дэмжих замаар түүхий нүүрсний хэрэглээг халж, хаягдал утааг бууруулах арга хэмжээг авна.
- 3.3.5. Дуу чимээний мэдрэгчийг суулгаж, оновчтой зохицуулалтыг хийх замаар дуу чимээний бохирдлыг бууруулна.
- 3.3.6. Ногоон байгууламж, орчны тохижилт, авто замын түгжрэл, хог хаягдал, хөрс, агаарын бохирдлыг шийдвэрлэхэд чиглэсэн ногоон хөгжлийн сантай болно.
- 3.3.7. Ногоон зээлийн санхүүжилтээр гэр хорооллын айл өрхүүдийн амины орон сууцны дулааны алдагдлыг бууруулах бодлого баримталж сууцаа дулаалах, утаагүй халаалтын хэрэгсэлд шилжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.


### **3.4. Хог хаягдлын менежмент**

- 3.4.1. Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд шилжинэ.
- 3.4.2. Хотын гудамж талбайн цэвэрлэгээ, хог ачиж тээвэрлэх үйлчилгээг түгжрэлийн ачаалалгүй цагаар буюу шөнийн хуваарьт шилжүүлэх ба үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.4.3. Дахин боловсруулах боломжтой хаягдал буюу дахивар цуглуулж тээвэрлэх тусгай хуваарьтай тээврийн үйлчилгээг хувийн хэвшилтэй хамтран нэвтрүүлнэ.
- 3.4.4. Дүүрэг бүрд хог хаягдлыг хүлээн авч ангилан ялгах дундын бичил төвүүдийг бий болгоно.
- 3.4.5. Автомашин болон автомашины гаралтай хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшилтэй хамтран барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 3.4.6. Хог ангилан шатаах замаар эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийг барьж, төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийг сайжруулна.
- 3.4.7. Лаг хатаах, шатаах үйлдвэрийг байгуулна.

## **4. ОРЛОГОТой ХОТ**

### **4.1. Хувийн хэвшлийг дэмжинэ**

- 4.1.1. Эрчим хүч, дулаан, ус, хог хаягдлын менежмент, нийтийн тээвэр, хүнсний хангамжийг чиглэлийн төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 4.1.2. Стандартад нийцсэн хүртээмжийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгаж, иргэд бизнес эрхлэх орчинг сайжруулж, зөвшөөрлийн тогтолцооноос стандарт хангасан тогтолцоонд шилжих орчинг бүрдүүлнэ.



- 4.1.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, стандарт хангасан бүтээгдэхүүнийг борлуулахад хотын зүгээс түнш байгууллагуудтай болж зах зээлээ өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.4. Улаанбаатар хотод гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж бодлогоор дэмжинэ.

#### **4.2. Нийслэлийн өмчийн зөв менежмент**

- 4.2.1. Нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийг хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй компани болгох шинэчлэлийг эхлүүлж, засаглалыг сайжруулан нийгэм, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.
- 4.2.2. Нийслэлийн өмчийн бүртгэл, хяналтын менежментийг сайжруулах цогц арга хэмжээ авч, өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өмчийн үнэ цэнийг өсгөн үр ашгийг нэмэгдүүлнэ.
- 4.2.3. Нийслэлийн өмч дэх үл хөдлөх хөрөнгүүдийн түрээсийн орлогыг үнэт цаасжуулах замаар хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө босгож, өмчийн үнэ цэнийг өсгөн, ашиглалтыг сайжруулна.
- 4.2.4. Хөрөнгө оруулалтын менежментийн компани, сангуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, хөрөнгө оруулалт татах замаар Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан эдийн засгийн үр ашиг бүхий төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.

#### **4.3. Хотын соёл, спорт урлаг, аялал жуулчлал**

- 4.3.1. Дэлхийн “Бүтээлч хотуудын сүлжээ”-д нэгдэж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбараар хотын эдийн засгийг өсгөж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.
- 4.3.2. Гандантэгчилэн хийд, Богд хааны ордон музей, “Кино үйлдвэр” орчим зэрэг хотын түүх, соёлын өвийг хамгаалан, төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- 4.3.3. Дамбадаржаа хийдийг сэргээн засварлаж, түүх соёлын өвийг хадгална.
- 4.3.4. Улаанбаатар хотын музейг шинэчлэн барьж байгуулна.
- 4.3.5. Нийслэлийн онцлогт тохирсон, түүх, археологи, нүүдлийн соёл, зан заншил, шашны биет болон биет бус түүх соёлын өв, байгалийн өвөрмөц байдлыг бүртгэлийн сан үүсгэж, нийтийн хүртээл болгон танилцуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.
- 4.3.6. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, хотын спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, 3x3 стандарт хангасан сагсан бөмбөгийн талбайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.

1117 145677  
УУА0612 9077278

- 4.3.7. “Улаанбаатар” олон улсын кино наадам, сонгодог урлагийн гала тоглолтыг жил бүр зохион байгуулдаг уламжлалыг үргэлжлүүлж, иргэд болон жуулчдыг татах уран бүтээлийн өвөрмөц санг баяжуулна.
- 4.3.8. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор-төвийн үйл ажиллагааг байгуулна.
- 4.3.9. Виртуал технологийг ашиглан музей, түүх, соёлын өвийн санг бий болгон ухаалаг аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

#### 4.4. Дагуул хот ба аж үйлдвэрийн парк

- 4.4.1. Налайх, Багануурыг улсын зэрэглэлтэй хот, Багахангайг Улаанбаатар хотын дагуул хот болгон хөгжүүлнэ.
- 4.4.2. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд **“Шинэ Зуунмод”** хот байгуулна.
- 4.4.3. Хүнсний нарийн ногоо, жимс жимсгэнэ ургуулах хүлэмжийн аж ахуйг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлэх замаар иргэдийг жилийн 4 улирлын туршид эрүүл, аюулгүй хүнсээр хангах боломжийг бүрдүүлэх **“Агро-Сити”** дагуул хотыг байгуулна.
- 4.4.4. **“Шарга морьт”** дагуул хотод амралт, хот орчмын аялал жуулчлалын бүсийг бий болгоно.
- 4.4.5. Улаанбаатар хотын хөгжлийг тэтгэж, ажлын байр, төвлөрлийг сааруулах аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ. Үүнд:
- 4.4.5.1. Багануурын “Нүүрс-Химийн цогцолбор” үйлдвэрлэл технологийн парк
- 4.4.5.2. Багахангайн хөнгөн үйлдвэрлэл голлосон үйлдвэрлэл технологийн парк
- 4.4.5.3. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк
- 4.4.5.4. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалт, арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх ажлыг дуусгана.
- 4.4.6. Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, хотын автозамын ачаалал, бараа эргэлтийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хүрээнд баруун, зүүн бүсэд ачаа тээврийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.

## 5. АЮУЛГҮЙ ХОТ

### 5.1. Хүрээлэн буй орчны оновчтой төлөвлөлт

- 5.1.1. Барилга, байгууламжийн орц гарцыг чөлөөтэй саадгүй болгож, өндөр хашаа, хаалтыг буулгаж, нам дор бут сөөгөн хашаажуулах бодлого хэрэгжүүлснээр амьдрах орчинг сайжруулна.
- 5.1.2. Хүүхдийн тоглоомын талбай, гудамж, явган хүний зам, нүхэн гарц, бичил цэцэрлэгт хүрээлэн дэх гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.

111714960  
УУАДС

- 5.1.3. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, агаар сэлгэгч болон цэвэршүүлэгчийн систем нэвтрүүлж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 5.1.4. Гэмт хэргийн эрсдэл өндөртэй байршлуудад иргэдийн саналаар ухаалаг камер, автомат дугаар уншигч, эргүүлийн дрон зэрэг дэвшилтэт технологийг ашиглана.

## **5.2. Инновац, хиймэл оюун ухаан, цахим үйлчилгээ**

- 5.2.1. Эрүүл аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системийг бий болгоно.
- 5.2.2. Гэрлэн дохиог их өгөгдөлд суурилсан тооцооллоор оновчилж, замын цагдаагийн хөдөлгөөн зохицуулалтыг бууруулна.
- 5.2.3. Хотын бохирдол, гамшиг осол, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх "IoT" камер, мэдрэгч төхөөрөмжүүдийг суурилуулна.
- 5.2.4. Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийг ухаалаг системд холбож засвар, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг оновчтой болгоно.
- 5.2.5. "E-Mongolia" шинэчлэлийг нийслэлийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад бүрэн нэвтрүүлж, мэдээллийг ил тод болгож, иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг бодитойгоор хэмнэнэ.
- 5.2.6. Нийслэлээс олгогддог бүх төрлийн зөвшөөрлийг цахимжуулах ажлыг үргэлжлүүлж, төрийн үйлчилгээний хурд, чанарыг нэмэгдүүлнэ.
- 5.2.7. Барилга байгууламж болон инженерийн дэд бүтцийн мэдээллийг нэгтгэж, хот төлөвлөлтийн бичиг баримтын хамт цахимаар ашиглах боломжийг бий болгож, бодлого боловсруулахад ашиглана.

## **5.3. Гамшгийн бэлэн байдал**

- 5.3.1. Онцгой байдлын байгууллагын аюул гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн болон албан хаагчдын чадавхыг сайжруулж, бэлэн байдлыг бэхжүүлнэ.
- 5.3.2. Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.
- 5.3.3. Хот төлөвлөлт, барилга байгууламжийн стандарт, норм, дүрэм журмыг боловсронгуй болгоно.
- 5.3.4. Их өгөгдөлд суурилсан гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх системийг эхлүүлнэ.
- 5.3.5. Хотын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулах чиглэлээр төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 5.3.6. Морин уулын цаг уурын доплерын радарын станцыг ашиглан цаг агаарын аюулын бодит мэдээг тодорхойлон олон нийтийн радио телевиз, боломжит

11171456  
УХА0012




мэдээллийн сувгийг ашиглан зарлан мэдээлж, аюулаас урьтаж иргэд бэлэн байдалд орох боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.7. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.

5.3.8. Сэлбэ болон Туул голд үерийн аюулаас сэргийлсэн тохируулга бүхий хөв цөөрөм, усан сан байгуулна.

5.3.9. Үерийн далан, ус зайлуулах шугамын өргөтгөл, усны хаялагын шинэчлэлтийг хийж, усанд автдаг зам, явган замын тоог бууруулна.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 984

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Баянгол дүүргийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Баянгол дүүргийн Монгол Ардын намын Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол дүүргийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Баянгол дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ**  
**2024-2028 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“УХААЛАГ БАЯНГОЛ - ХӨТӨЛБӨР”-ИЙН АГУУЛГА**



**Улаанбаатар хот 2024**





## БАЯНГОЛ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ

2024-2028 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### “УХААЛАГ БАЯНГОЛ - ХӨТӨЛБӨР”-ИЙН АГУУЛГА

#### 1. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЯНГОЛ

- 1.1. Сургууль цэцэрлэгийн хүртээмж
- 1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж
- 1.3. Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих бодлого
- 1.4. Хүүхэд, залуусын хөгжлийг дэмжих бодлого
- 1.5. Ахмад настны хөгжил

#### 2. ТОХИЛОГ БАЯНГОЛ

- 2.1. Иргэдийн тав тух, тохилог аюулгүй ногоон орчин бүрдүүлэх
- 2.2. Иргэдийн амар тайван амьдрах таатай орчин бүрдүүлэх
- 2.3. Хог хаягдлын менежмент
- 2.4. Агаар, хөрсний бохирдол
- 2.5. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал

#### 3. ДЭД БҮТЭЦ, ТӨЛӨВЛӨЛТ

- 3.1. Орон сууцжуулах бодлого
- 3.2. Эрчим хүч, дулаан хангамж
- 3.3. Авто зам, нийтийн тээврийн хүртээмж
- 3.4. Гамшгийн бэлэн байдал

#### 4. БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН

- 4.1. Бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого
- 4.2. Түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх бодлого

#### 5. ЦАХИМ ЗАСАГЛАЛ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1. Цахим засаглал, төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого
- 5.2. Мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэн хөгжүүлэх бодлого



## “УХААЛАГ БАЯНГОЛ- ХӨТӨЛБӨР”


### 1. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЯНГОЛ

#### 1.1. Сургууль цэцэрлэгийн хүртээмж

- 1.1.1. Шинээр сургууль цэцэрлэг байгуулах, өргөтгөх замаар бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд байлгаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.2. Хүүхэд өнжүүлэх төвийг (иргэд нийтийн төв, community center) хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулна.
- 1.1.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын ачааллыг бууруулах зохицуулалтыг хийнэ.
- 1.1.4. Багш нарын хөгжлийг дэмжих, мэдлэг, мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн чиглэлийн ажлууд зохион байгуулна.
- 1.1.5. Сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулна.
- 1.1.6. Стандартад нийцсэн хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй суралцахад таатай орчин нөхцөл бүрдүүлнэ.
- 1.1.7. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт хотын соёл, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.8. Цэцэрлэгийн хоол болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолны стандартыг шинэчлэн, илчлэгт анхаарч, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.
- 1.1.9. Ерөнхий боловсролын сургуулийн хэрэгцээ өндөртэй байгаа гэр хорооллын байршилд хүн амын нягтаршил, өсөлт, хүртээмжийг үндэслэн гэрт хамгийн ойр сургууль барих ажлыг шат дараатай хэрэгжүүлж, амьдарч буй орчиндоо чанартай боловсролын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.10. “МОНГОЛ ХҮН” бэлтгэх бодлогын хүрээнд уламжлалт боловсрол, зан чанарын төлөвшил хүмүүжил, өв соёл, сургаал, амьдрах ухааныг тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай уялдуулан нийцүүлсэн насан туршийн боловсролын төвүүдийг нэмэгдүүлнэ.

#### 1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж

- 1.2.1. 20 минутын зайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 1.2.2. Дүүргийн Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн орчин нөхцөл, нарийн мэргэжлийн тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.2.3. Эмч, ажилчдын мэдлэг ур чадварыг сайжруулах ажлуудыг шат дараатай зохион байгуулна.
- 1.2.4. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлэн хэрэгжинэ.
- 1.2.5. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвүүдийг байгуулна.
- 1.2.6. Дүүргийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.



- 1.2.7. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулна.


#### **Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих бодлого**

- 1.3.1. 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулах, цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийн зохицуулалтыг хийх замаар эцэг, эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.2. Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Баянгол-Хүүхэд хэрэглэгч” хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.3. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд “Аав, эрчүүд”, “Чанартай амьдрал-аавуудын оролцоо” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4. Залуу гэр бүл, залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Баянгол-Залуучуудын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.5. Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, гэр бүлийн салалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох олон талт үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

#### **Хүүхэд, залуусын хөгжлийг дэмжих бодлого**

- 1.4.1. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулж, сум, хороо бүрд гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын нийгмийн ажилтантай болгоно.
- 1.4.2. Иргэдэд албан бус, насан туршийн боловсролын төвөөр дамжуулан тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлнэ.
- 1.4.3. Хүүхэд залуучуудад чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, өөрийн мэдлэг авьяас чадвараа хөгжүүлэх боломжийг тэгш хүртээмжтэй хүргэнэ.
- 1.4.4. “Баянгол хүүхдийн зуслан”-г төрөлжсөн хөтөлбөртэй болгож, зуны болон өвлийн амралтаа бүтээлч байдлаар өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.4.5. Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг хангуулж, арчлалт үйлчилгээг оршин суугчдын оролцоотойгоор тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангана.
- 1.4.6. Сургуулийн боловсролын хөтөлбөрт эрүүл мэнд, хог хаягдал, байгаль орчин, ажил мэргэжил, замын аюулгүй байдлын талаар салбарын мэргэжилтний хичээлийг нэвтрүүлнэ.
- 1.4.7. Баянгол цэцэрлэгт хүрээлэнг 4 улирлын турш ашиглах боломжтой, орчин үеийн спорт цогцолбор, амралт чөлөөт цагийн төв болгон хөгжүүлж, залуучуудын спорт, соёлын арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.4.8. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх “бизнес инкубатор төв”-ийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.
- 1.4.9. Залуучуудын орлогоо нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих бодлого боловсруулж, хэрэглээний программ, аппликейшн бүтээх чадвар бүхий залуусыг дэмжиж “Цахим төв”-ийг байгуулна.
- 1.4.10. Хүүхэд залуучуудын согтууруулах ундаа, тамхи татах зуршлыг багасгах хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

#### **1.5. Ахмад настны хөгжил**



*Signature*



- 1.5.1. Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр гарсан санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.5.2. Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцсэн байдлаар байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 1.5.3. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.5.4. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- 1.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг шинээр тавих зам харгуй, нийтийн тээвэр болон төрийн байгууллагуудад мөрдүүлнэ.

## ТОХИЛОГ БАЯНГОЛ

### Иргэдийн тав тух, тохилог аюулгүй ногоон орчин бүрдүүлэх

- 2.1.1. Баянгол дүүргийн "Орон зайн бүсчлэл"-г хот байгуулалтын батлагдсан баримт бичгийн дагуу бүсчлэн хөгжүүлнэ. Дүүргийг онцлог хэв шинж, газар нутгийн байрлалаар нь 6 кластерт хуваан хөгжүүлнэ.
- 2.1.2. Хөгжлийн урт хугацааны баримт бичиг болох "Алсын хараа 2050" үзэл баримтлалын хүрээнд идэвхтэй, орон зайн оновчтой төлөвлөлттэй, эрүүл цэвэр орчинтой үйлдвэрлэгч дүүрэг болгох судалгаа, зураглалын ажлыг нийслэлийн удирдлагын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулна.
- 2.1.3. Орон сууцны болон олон нийтийн барилгын гадна фасадын өнгө үзэмжийг сайжруулна.
- 2.1.4. "Эрүүл Монгол хүн хөдөлгөөн"-ний хүрээнд иргэд, хүүхэд залуучуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор спортын цогцолбор, биеийн тамирын төрөлжсөн талбайг нэмэгдүүлнэ.
- 2.1.5. Баянгол дүүргийн хэмжээнд өөрийн өвөрмөц дүр төрхтэй, олон зориулалт бүхий гудамж, талбайг барьж байгуулах, тохижуулна.
- 2.1.6. Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллага, орон сууц, гэр хорооллын газрын ногоон байгууламжийн нэг хүнд ноогдох талбайг нэмэгдүүлнэ.
- 2.1.7. "Баянгол цэцэрлэгт хүрээлэн"-гийн тохижилтын ажлыг үргэлжлүүлж иргэдэд зориулсан хөтөлбөр, өдөрлөгүүдийг зохион байгуулна.
- 2.1.8. "Баянгол өндөрлөг" цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг эхлүүлнэ.
- 2.1.9. Үйлдвэрийн бүсээс дэгдэх тоосжилт, дуу чимээг багасгах зорилгоор техникийн зориулалттай ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.10. Гэр суурьшлын бүсээс дэгдэх тоосжилтыг дарах зорилгоор техникийн зориулалттай ногоон байгууламжийг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- 2.1.11. Иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, салхилах зориулалттай өөрийн өвөрмөц дүр төрх, олон зориулалт бүхий гудамж, талбайнуудыг тохижуулах, шинээр байгуулах ажлыг зохион байгуулна.





- 2.1.12. Айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг урамшуулан, мод ургуулах дадлыг бий болгох арга замаар дэмжиж ажиллана.
- 2.1.13. Дунд голын эргийн дагуу, дэд төвүүдэд иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчин, уул толгодтой холбогдсон ногоон сүлжээ, дугуйн болон гүйлтийн замын холболтын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эхлүүлнэ.
- 2.1.14. Гэр хорооллын бүсэд гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлсэн, эрчим хүчний хэмнэлт бүхий ногоон "Нийтийн ахуйн үйлчилгээний төсөл"-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 2.1.15. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрт нэгдэж боломжит зай талбайд мод тарих, цэцэрлэгжүүлэх, тохижуулах ажлыг хийж иргэдийн ая тухай, цэвэр цэмцгэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Иргэдийн амар тайван амьдрах таатай орчин бүрдүүлэх**

- 2.2.1. Гэрэлтүүлгийг сайжруулах, гэрэлтүүлэггүй болон доголдол тасалдалтай хэсгүүдэд бүрэн гэрэлтүүлэг хийх мөн дүүргийн өнгө төрх бүхий гэрэлт гудамжуудыг байгуулна.
- 2.2.2. Иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гудамж, талбайг камержуулах, ухаалаг камерын системтэй дүүрэг болно.
- 2.2.3. Гэмт хэргийн эрсдэл өндөртэй байршлуудад иргэдийн саналаар ухаалаг камер, автомат дугаар уншигч, эргүүлийн дрон зэрэг дэвшилтэт технологийг ашиглана.
- 2.2.4. Барилга, байгууламжийн орц гарцыг чөлөөтэй саадгүй болгож, өндөр хашаа, хаалтыг буулгаж, нам дор бут сөөгөн хашаажуулах бодлого хэрэгжүүлснээр амьдрах орчинг сайжруулна.
- 2.2.5. Цэцэрлэг, сургуулийн орчны стандартыг хангуулж, замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлнэ.
- 2.2.6. Алхах, дугуй унахад аюулгүй тав, тухтай байдлыг ханган хотын хөдөлгөөн хязгаарлаж буй хашаа, хаалтуудыг үргэлжлүүлэн буулгана.
- 2.2.7. Автомашингүй өдрийг сард нэг удаа зохион байгуулах ажлыг иргэд, хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

### **2.3. Хог хаягдлын менежмент**

- 2.3.1. Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд шилжинэ.
- 2.3.2. Дахин боловсруулах боломжтой хаягдал буюу дахивар цуглуулж тээвэрлэх тусгай хуваарьтай тээврийн үйлчилгээг хувийн хэвшилтэй хамтран нэвтрүүлнэ.
- 2.3.3. Гэр хорооллын болон орон сууцны хорооллын хог хаягдлыг ангилан ялгаж эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлнэ.
- 2.3.4. Хотын гудамж талбайн цэвэрлэгээ, хог ачиж тээвэрлэх үйлчилгээг түгжрэлийн ачаалалгүй цагаар буюу шөнийн хуваарьт шилжүүлэх ба үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.5. Хог ачилт болон цэвэрлэгээний ажлыг тогтмолжуулан иргэдтэй хамтран орчны цэвэр цэмцгэр байдлыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.3.6. Гэр хорооллын болон орон сууцны хорооллын гадна зам талбайд стандартын дагуу хогийн савтай болгох ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.3.7. Орон сууцны хорооллын хог хаягдлыг СӨХ-дтой хамтран цаас, хуванцар, ахуйн хог хаягдал ангилах үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих



*Handwritten signature*



- 2.3.8. Иргэдийн аюулгүй байдлыг хангах хүрээнд золбин нохой, муурын устгалын ажлыг зохион байгуулж цаашлаад золбин нохой, муурыг бууруулахад дэвшилтэт аргуудыг (тарилга, спэй) ашиглана

#### 2.4. Агаар, хөрсний бохирдол

- 2.4.1. Гэр хорооллын айл өрхүүдийн амины орон сууцны дулааны алдагдлыг бууруулах бодлого баримталж сууцаа дулаалах, утаагүй халаалтын хэрэгсэлд шилжих нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 2.4.2. Гэр суурьшлын бүсийн худгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, одоо байгаа худгийн чанар стандартад хяналт тавина.
- 2.4.3. Гэр хорооллыг орон сууцжуулах, нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, хөрсний бохирдлыг бууруулах стандарт, нөхөн сэргээх, ногоон байгууламжуудыг бий болгох ажлыг цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.
- 2.4.4. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, иргэдийн хашааг орон сууцаар солих нөхцөл, эрх зүйн орчныг бий болгоно, яндангийн тоог цөөлнө.
- 2.4.5. Гэр хорооллын айл өрхүүдийг угаарын хийнд хордох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 2.4.6. Дүүргийн гэр хорооллын бүсийн айл өрхүүдэд түлш жижиглэн борлуулах цэгээр дамжуулан сайжруулсан түлшээр хангах ажлыг зохион байгуулна.

#### 2.5. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал

- 2.5.1. “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, чанарын хяналт удирдлагын тогтолцоог сайжруулах бодлогыг дэмжин ажиллана.
- 2.5.2. Дүүргийн иргэдийг хямд чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5.3. Хүнс, нарийн ногоо, жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалт, баталгаатай хүнсээр хангах тогтолцоог анхаарч, төр хувийн түншлэлээр шийднэ.

### 3. ДЭД БҮТЭЦ, ТӨЛӨВЛӨЛТ

#### 3.1. Орон сууцжуулах бодлого

- 3.1.1. “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.1.2. “Миний ажилтан орон сууцтай” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид болон ажилтандаа орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлсэн хувийн хэвшлийн ААН-үүдэд хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.1.3. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэх, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 3.1.4. Орон сууцны хорооллуудын авто зогсоолын талбайг нэмэгдүүлнэ.
- 3.1.5. Орон сууцны сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.1.6. Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, амины болон нийтийн зориулалттай орон сууцжуулах бодлого хэрэгжүүлнэ.



- 3.1.7. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг улс, нийслэлтэй хамтарч шинээр орон сууцжуулах ажлыг эрчимжүүлнэ.
- 3.1.8. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчилнэ.

#### **.Эрчим хүч, дулаан хангамж**

- 3.2.1. Угсармал орон сууцнуудад дулаан техникийн шинэчлэлийн төсөл хэрэгжүүлэн дулаан алдагдлыг бууруулах замаар эрчим хүчийг хэмнэнэ.
- 3.2.2. Гэр хорооллын айл өрхүүд, аж ахуйн нэгжид баттерей бүхий нарны цахилгаан эх үүсгүүр суурилуулж яндангийн тоог бууруулна.
- 3.2.3. Дүүргийн мэдээлэл, харилцаа холбоо, холбоо дохиоллын хангамжийг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

#### **.Авто зам, нийтийн тээврийн хүртээмж**

- 3.1.3. Дугуйн замын маршрутыг явган болон ногоон байгууламжтай хамт төлөвлөж, бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- 3.1.4. Улаанбаатар хотын гол гудамж замуудыг нэмэгдүүлж, "бүрэн гудамж" стандартад хүргэж өргөтгөнө.
- 3.1.5. Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд газар дээрх, газар доорх, автомат олон давхар, их багтаамжийн зэрэг бүх төрлийн авто зогсоолыг хувийн хэвшилтэй хамтран хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулах "Авто зогсоол хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.
- 3.1.6. Гэр хорооллын нийтийн тээврийн хүртээмжгүй бүсэд 16 чиглэлийн дунд оврын автобусны үйлчилгээ, автобусны буудлуудыг ашиглалттай болгох ажлыг хувийн хэвшилтэй хамтран эхлүүлнэ.

#### **3.4. Гамшгийн бэлэн байдал**

- 3.4.1. Онцгой байдлын байгууллагын аюул гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн болон албан хаагчдын чадавхыг сайжруулж, бэлэн байдлыг бэхжүүлнэ.
- 3.4.2. Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.
- 3.4.3. Дүүргийн инженерийн бэлтгэл арга хэмжээг сайжруулах, үерээс хамгаалах арга хэмжээ далан шуудууг шинээр төлөвлөх, гуу жалгыг ашигтай төлөвлөх, хөрс цасны нуралтаас хамгаалах бэлтгэл арга хэмжээг авна.

### **4.БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН**

#### **.1.Бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого**

- 4.1.1. Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор төрийн болон бусад томоохон аж ахуйн нэгж, гадны улс, хотуудтай холбон зуучлах, туршлага судлуулах, хамтран ажиллах ажлуудыг зохион байгуулна.
- 4.1.2. Бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар Баянгол брэндийг бий болгоно.
- 4.1.3. Төрийн байгууллагууд, ААНБ-уудын хамтран ажиллах түншлэлийг сайжруулан, эрэлтэд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.4. Худалдаа, үйлдэрлэл болон зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчид зэрэг салбаруудад чиглэсэн маркетинг, чанарын менежментийн төрөлжсөн сургалтуудыг явуулж, бизнес эрхлэгчдийг чадавхжуулна.



*[Handwritten signature]*



- 4.1.5. Худалдаа үйлчилгээний төвүүд, худалдааны гудамжийг хөгжүүлж, бүсчилсэн хэлбэрээр хороодод үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.
- 4.1.6. Зочид буудал, шөнийн цэнгээний газар, караоке, нийтийн хоолны үйлчилгээний газруудад үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдлыг хангуулна.
- 4.1.7. Жижиг, дунд бизнесүүдэд зээл, тусламж үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар жижиг, дунд бизнесүүдийн санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэж ажиллана.
- 4.1.8. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмын дагуу хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

## **.2.Түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх бодлого**

- 4.2.1. Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг “Үндэсний соёлын өвийн дурсгалт газар” концепцоор хөгжүүлж “Буддын шашны соёлын өвийн цогцолбор” болгоно.
- 4.2.2. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор-төвийн үйл ажиллагааг байгуулна.
- 4.2.3. Жуулчдад зориулсан дүүрэг дэх аялал жуулчлалын маршрут бүхий дүүргийн брэндийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан ААНБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулсан гарын авлагыг гаргана.


## **5.ЦАХИМ ЗАСАГЛАЛ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

### **5.1. Цахим засаглал, төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого**

- 5.1.1. “E-Mongolia” шинэчлэлийг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад бүрэн нэвтрүүлж, мэдээллийг ил тод болгож, иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг бодитойгоор хэмнэнэ.
- 5.1.2. Дүүргийн төрийн байгууллагуудын зорилт, чиг үүргийн байдалд судалгаа хийж ажил үүргийн байдалд судалгаа хийж ажил үүргийн давхардлыг арилгана.
- 5.1.3. Бүх төрлийн зөвшөөрлийг цахимжуулах ажлыг үргэлжлүүлж, төрийн үйлчилгээний хурд, чанарыг нэмэгдүүлнэ.
- 5.1.4. Бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлнэ.
- 5.1.5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын механизмыг бий болгож, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.1.6. Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшил, иргэдийн оролцооны байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.
- 5.1.7. Цахим хэлбэрт оруулж болох төрийн бүх үйлчилгээг дүүргийн нутаг дэвсгэрт нэвтрүүлнэ.
- 5.1.8. Цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

### **5.2. Мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэн хөгжүүлэх бодлого**

- 5.2.1. Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлэн, төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлнэ.
- 5.2.2. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил бүр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтлана.



*Signature*



- 5.2.3. Төрийн албан хаагчдыг цахимаар, зайнаас, гэрээс ажиллах ажил эрхлэлтийн уян хатан зохицуулалтыг өргөжүүлнэ.
- 5.2.4. Төрийн тусгай алба хаагчдын хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.



A handwritten signature in black ink, consisting of stylized cursive letters.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 981

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Баянзүрх дүүргийн Монгол ардын нам хорооны мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Баянзүрх дүүргийн Монгол Ардын намын хорооны Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянзүрх дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Баянзүрх дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН АЙМАГ,  
НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Улаанбаатар хот  
2024 он





## АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ.....	1
1.1. Эрүүл мэнд.....	1
1.2. Боловсрол.....	2
1.3. Нийгмийн бүлэг.....	2
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТ.....	3
2.1. Жижиг дунд үйлдвэрлэл.....	3
2.2. Хөдөө аж ахуй.....	4
2.3. Аялал жуулчлал, соёл урлаг.....	4
ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ.....	5
3.1. Тогтвортой засаглалын бодлого.....	5
3.2. Төрийн үйлчилгээ.....	5
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ.....	5
4.1. Ногоон байгууламж.....	5
4.2. Агаар, ус, хөрсний бохирдол, хог хаягдлын менежмент.....	5
ТАВ. ХОТЖИЛТЫН СЭРГЭЛТ.....	6
5.1. Дэд төв.....	6
5.2. Олон төрөлт нийтийн тээврийн үйлчилгээ.....	6
5.3. Автозамын сүлжээ.....	6
5.4. Аюулгүй байдал.....	7




Баянзүрх дүүргийн Монгол  
Ардын Намын тэргүүлэгчдийн  
2024 оны 06 сарын 22-ний өдрийн  
хуралдаанаар батлав.

## БАЯНЗҮРХИЙН СЭРГЭЛТ – БҮТЭЭЛЧ ДҮҮРЭГ ХӨТӨЛБӨР

### НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

#### 1.1. Эрүүл мэнд

- 1.1.1. Дүүргийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүр 20 минутын зайд авах нөхцөл боломжийг бүрдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 1.1.2. Эрүүл мэндийн даатгалаас зардлыг нь хариуцан зохион байгуулдаг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд иргэдийг жил бүр хамруулна.
- 1.1.3. Хүн амын дундах халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлж, өсвөр үе, залуучуудын бэлгийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн аяныг жил бүр хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Дүүргийн нэгдсэн болон хүүхдийн төрөлжсөн эмнэлгийг ашиглалтад оруулж, стандартад нийцсэн, орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангана.
- 1.1.5. Жишиг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгыг хороодод үе шаттай ашиглалтад оруулна.
- 1.1.6. "Явуулын эмнэлэг-мобайл технологи" ашиглан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.7. Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдыг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гадаад оронд дадлага, туршлага эзэмшүүлнэ.
- 1.1.8. Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах бодлогыг жил бүр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.1.9. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийг дэмжиж, дүүргийн иргэдийн эрүүл, зөв амьдрах дадал, хэвшлийг дээшлүүлнэ.
- 1.1.10. Бүх насны иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчныг бүрдүүлж, нийтийн эзэмшлийн болон спортын цогцолбор талбайг үе шаттайгаар тохижуулна.
- 1.1.11. Баянзүрх дүүргийн спорт цогцолборыг 11-р хороо буюу Хонхорт ашиглалтад оруулна.



1  
Am




## 1.2. Боловсрол

- 1.2.1. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн автобусны үйлчилгээг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 1.2.2. Эх хэлний бодлоготой уялдуулан дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн "Англи хэл-Хос хэл" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.2.3. Ерөнхий боловсролын сургуулиудыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон шинжлэх ухааны танхимтай болгоно.
- 1.2.4. Ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг стандартад нийцүүлэн үе шаттайгаар шинэчилнэ.
- 1.2.5. Насан туршийн суралцахуйн төвөөр олгох сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль завсардалтыг танхим болон онлайн сургалтаар нөхөх боломжийг бүрдүүлнэ.
- 1.2.6. Төгсөх ангийн сурагчдын боловсролыг дэмжих хүрээнд тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлнэ.
- 1.2.7. Хүүхэд залуусын техник сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор мэргэжлийн их, дээд сургуулиудтай хамтран "STEM Техник сэтгэлгээний төв" байгуулна.
- 1.2.8. Ерөнхий боловсролын сургууль бүрд сэтгэл зүйч ажиллах боломжийг бүрдүүлж, хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулна.
- 1.2.9. Цэцэрлэгийн барилгыг барих, өргөтгөх замаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын анги дүүргэлтийг бууруулна.
- 1.2.10. Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг барих, өргөтгөх замаар ерөнхий боловсролын сургуулийн барилгын ашиглалт, ээлжийн коэффициентийг бууруулж, бүх сургуулийг 2 ээлжтэй болгоно.
- 1.2.11. Монгол ёс заншил, туслах аж ахуйн чиглэлээр боловсрол, төлөвшлийг олгох зорилгоор хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эрхлэхийг бодлогоор дэмжинэ.
- 1.2.12. Орчин үеийн мэдээлэл, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн дүүргийн номын санг шинээр байгуулна.
- 1.2.13. Бүх шатны боловсролын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар хангаж, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.2.14. Багшлах боловсон хүчнийг мэдлэг боловсролоо дээшлүүлэхийг дэмжиж, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гадаад оронд дадлага, туршлага эзэмшүүлнэ.
- 1.2.15. Боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах бодлогыг жил бүр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

## 1.3. Нийгмийн бүлэг

### 1.3.1. Гэр бүл

- 1.3.1.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах олон талт ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.



 2



- 1.3.1.2. Гэр бүл төлөвлөлтийн бүх талын мэдлэгийг олгох зорилгоор ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудтай хамтарсан нөлөөллийн аяныг тогтмол хэрэгжүүлнэ.
- 1.3.1.3. Жендерийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлж, чадавхыг бэхжүүлнэ.
- 1.3.1.4. Залуу ээжүүдийн хөгжлийн төвийг ашиглалтад оруулна.

### **1.3.2. Хүүхэд, залуучууд**

- 1.3.2.1. Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг сайжруулан, аюулгүй орчныг бүрдүүлж, арчлалт хамгаалалтыг сайжруулна.
- 1.3.2.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн ойр орчмын гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер хурд сааруулагчийг нэмэгдүүлж эрүүл, аюулгүй орчинд суралцах нөхцөлийг хангана.
- 1.3.2.3. Хүүхэд залуучуудыг хотын соёл, эрүүл амьдралын хэв маяг, дадал зан үйлд сургах хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.3.2.4. Цахим спортыг дэмжих, үйл ажиллагааг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.2.5. Дүүргийн өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжинэ.

### **1.3.3. Ахмад настан**

- 1.3.3.1. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3.3.2. Дүүргийн нутаг дэвсгэрийн хүн амын суурьшлаас хамааруулан "Ахмадын өргөө" байгуулна.

### **1.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

- 1.3.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, нийгмийн тусламж, үйлчилгээ авах нөхцөл, үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 1.3.4.2. Бүх шатны төрийн байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.
- 1.3.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, спорт заалыг ашиглалтад оруулна.
- 1.3.4.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг бууруулах, бүх шатны боловсролд тэгш хамрагдах боломжийг олгоно.
- 1.3.4.6. Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн дэд бүтцийн стандартыг мөрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТ**

### **2.1. Жижиг дунд үйлдвэрлэл**

- 2.1.1. Шинэ техник технологи, инновац нэвтрүүлсэн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжинэ.




- 2.1.2. Арилжааны дүүрэг төслийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжүүдэд худалдаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.3. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зах зээлийг өргөтгөх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна.
- 2.1.4. Иргэдийг худалдаа хийх, үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж "Шөнийн худалдаа" бий болгоно.
- 2.1.5. Үйлдвэрлэл-Инновацын төвийн барилгын ажлыг эрчимжүүлнэ.

## 2.2. Хөдөө аж ахуй

- 2.2.1. Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор газар тариалан эрхлэгчдийг дэмжинэ.
- 2.2.2. Дүүргийн нутаг дэвсгэрт "Ногоон агро" кластерийн төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.2.3. Дүүргийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр иргэдийг сургаж бэлтгэх, дадлагажуулах, шилдэг технологи, инновацыг судлуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.2.4. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зоорийн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, фермерийн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжинэ.

## 2.3. Аялал жуулчлал, соёл урлаг

- 2.3.1. Дүүргийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгалийн онцлог, өвөрмөц тогтоц бүхий газруудад аялал жуулчлалын бүсийг бий болгоно.
  - 2.3.2.1. Уулын аяллын бүс;
  - 2.3.2.2. Экстрем, спорт аяллын бүс;
  - 2.3.2.3. Дугуйн замын аяллын бүс;
- 2.3.3. Арилжааны дүүрэг төслийн хүрээнд "Бүтээлч гудамж"-уудыг бий болгоно.
  - 2.4.4.1 Кино урлагийн гудамж;
  - 2.4.4.2 Худалдаа, үйлчилгээний гудамж;
  - 2.4.4.3 Автомашины засвар, үйлчилгээний гудамж;
- 2.4.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлд үндэслэн соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдлыг хамгаалан, хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлнэ.
- 2.4.5. Дүүргийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагаанд стандартын хэрэгжилтийг хангуулна.





## ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

### 3.1. Тогтвортой засаглалын бодлого

- 3.1.1. Дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар үр өгөөжтэй, нийтийн эрх ашигт нийцсэн бүтээн байгуулалтыг иргэдтэй зөвлөлдөж хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Төсвийн зарцуулалтын ил тод байдлыг сайжруулж, хяналтыг нэмэгдүүлнэ.
- 3.1.3. Дүүргийн өмчийн бүртгэл, хяналтын менежментийг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар үр ашгийг дээшлүүлнэ.
- 3.1.4. Инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжих "Тинк танк" хүрээлэн байгуулна.
- 3.1.5. "Хөгжлийн зураглал 2030" дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
- 3.1.6. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.

### 3.2. Төрийн үйлчилгээ

- 3.2.1. Нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг ойртуулж, 20 минутын зайд авах боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.2. Төрийн албаны хүний нөөцийг авлигаас ангид, мэргэшсэн, туршлага, ур чадвартай нөөцөөр бүрдүүлнэ.
- 3.2.3. Төрийн үйлчилгээг цахимжуулах замаар иргэдэд түргэн, шуурхай хүргэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.2.4. "Дуудлага, мэдээллийн төв" байгуулна.


## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

### 4.1. Ногоон байгууламж

- 4.1.1. Бичил цэцэрлэгт хүрээлэнг хороо бүрд үе шаттай байгуулна.
- 4.1.2. Нийтийн эзэмшлийн талбайд зөвшөөрөлгүй барьсан байгууламжийг буулгаж, иргэдийн хүсэлтийн дагуу тохижуулах ажлыг эрчимжүүлнэ.
- 4.1.3. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор "Айл бүр 10 мод" аяныг үргэлжлүүлнэ.

### 4.2. Агаар, ус, хөрсний бохирдол, хог хаягдлын менежмент

- 4.2.1. Ундны усны эх үүсвэрийн чанар, аюулгүй байдлын суурь судалгааг хийж, дүүргийн "Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө" боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Хүн амын тоо, газар зүйн байршлын онцлогт нийцүүлэн ухаалаг системд холбогдсон гүний худаг, зөөврийн усан санг нэмэгдүүлнэ.
- 4.2.3. Ундны усны эх үүсвэрүүдийг хамгаалалтад авч, арчлалт, ашиглалтыг сайжруулна.





- 4.2.4. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд саарал усыг ашиглах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.5. Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, иргэдийг хамгаалах зорилгоор Туул, Сэлбэ, Улиастай голын эргийн хамгаалалтын далан болон ус зайлуулах суваг, хураагуур байгуулна.
- 4.2.6. "Сэлбэ сэргэлт" төслийг эрчимжүүлнэ.
- 4.2.7. Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах хөтөлбөрүүдэд иргэдийг идэвхтэй хамруулна.
- 4.2.8. Ундны цэвэр усны эх үүсвэр, голын ай сав дагуух гэр хорооллын ариун цэврийн нүхэн байгууламжийг бууруулах ажлыг эрчимжүүлнэ.

## **ТАВ. ХОТЖИЛТЫН СЭРГЭЛТ**

### **5.1. Дэд төв**

- 5.1.1. "Шархад" дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.
- 5.1.2. Нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр засвар, гадна фасадны засварын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлт болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг барилгажуулахад мөрдөгдөж буй эрх зүйн орчныг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.
- 5.1.4. Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.

### **5.2. Олон төрөлт нийтийн тээврийн үйлчилгээ**

- 5.2.1. Их багтаамжийн нийтийн тээврийн төслүүд болон метроны бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.
- 5.2.2. Гэр хорооллын нийтийн тээврийн хүртээмжгүй бүсэд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 5.2.3. Автозамын сүлжээтэй уялдуулан дулаан автобусны буудлыг үе шаттай нэмэгдүүлнэ.

### **5.3. Автозамын сүлжээ**

- 5.3.1. Улаанбаатар хотын автозамын сүлжээтэй уялдуулан дүүргийн нутаг дэвсгэрт автозамын цогц төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.3.2. Иргэдийн эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор явган болон дугуйн замын бүтээн байгуулалтыг нэмэгдүүлнэ.
- 5.3.3. Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ил болон давхар зогсоолуудыг бий болгоно.

6

#### 5.4. Аюулгүй байдал

- 5.4.1. Нийтийн эзэмшлийн зам, талбайн орц гарцыг чөлөөтэй саадгүй болгож, өндөр хашаа, хаалтыг буулгах ажлыг хэрэгжүүлнэ.
- 5.4.2. Дүүргийн хэмжээнд нэгдсэн камержуулалтын системийг нэвтрүүлнэ.
- 5.4.3. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 5.4.4. Иргэд олон нийтэд зориулсан "Эрх зүйн туслалцаа үзүүлэх төв" байгуулна.

1117145633  
УХА0612 9077278

**БОЛОВСРУУЛСАН:**

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ



----- оОо -----





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 991

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД СОНГИНОХАЙРХАН  
ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР



2024 ОН



## АГУУЛГА

1. ЗАСАГЛАЛ	2
2. ДЭД БҮТЭЦ	2-3
3. ЭДИЙН ЗАСАГ	3-4
4. ХҮНИЙ ХӨГЖИЛ	4-5
5. НОГООН ХӨГЖИЛ	5-6
6. ОРОН СУУЦНЫ ХҮРТЭЭМЖ	6



## СОНГИНОХАЙРХАН – ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

20 минутын хот

### ЗОРИЛТ 1. ЗАСАГЛАЛ


Дүүргийн ирээдүйн 30 жилийн хөгжлийн суурь болох засаг захиргааны бүтцийн эрс шинэчлэл хийнэ.

Хэт төвлөрөл, суурьшлын бүсийн тэлэлтээс үүдсэн хотын төв рүү тэмүүлсэн урсгалыг сааруулж дүүргийг 4 хот болгон хөгжүүлэх замаар иргэд өөрийн гэрээс “20 МИНУТЫН ЗАЙ”-д нийгмийн үйлчилгээг шуурхай авах бололцоог бүрдүүлнэ.

- 1.1. Эрх мэдэл, төсөв санхүүгийн хувьд нэгдсэн удирдлагаас хамааралтай байсан 43 хороодыг 13 хороолол болгон дүүргийн нутаг дэвсгэрт 4 хот байгуулах замаар эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломжийг бүрдүүлнэ. (Улсын төсөв)
- 1.2. Алдаатай төлөвлөлттэй орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, нийгмийн үйлчилгээ, автозогсоол, ногоон байгууламж, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 1.3. Асуудлын шалтгаанд суурилсан хөрөнгө оруулалтыг хийх замаар иргэдэд тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдал, тэгш бус хүртээмжээс урьдчилан сэргийлнэ.
- 1.4. Орон зайн мэдээллийн нээлттэй платформоор дамжуулан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын мэдээллийг ил тод, ойлгомжтой болгоно. (Нийслэлийн төсөв)
- 1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргаж, нутгийн захиргааны байгууллагуудын зарим чиг үүргийг хувийн хэвшилд үе шаттайгаар шилжүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 1.6. Гэмт хэргийн эрсдэл өндөртэй байршлуудад иргэдийн саналаар ухаалаг камер, автомат дугаар уншигч, эргүүлийн дрон зэрэг дэвшилтэт технологийг ашиглана. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 1.7. Ухаалаг “E-Mongolia” хиймэл оюун ухааны шинэчлэлийг дүүргийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад бүрэн нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг бодитойгоор хэмнэнэ. (Улсын төсөв)
- 1.8. Дүүргээс олгогддог бүх төрлийн зөвшөөрлийг цахимжуулах ажлыг үргэлжлүүлж, төрийн үйлчилгээний хурд, чанарыг нэмэгдүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 1.9. Онцгой байдлын байгууллагын аюул гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулж, бэлэн байдлыг бэхжүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 1.10. Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ. (Дүүргийн төсөв)
- 1.11. Аюулгүй дүүрэг хөтөлбөр хэрэгжүүлнэ. (Дүүргийн төсөв)

### ЗОРИЛТ 2. ДЭД БҮТЭЦ

Гэр хорооллын өрхийг цахилгаан, эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбож, дулааныг төвлөрсөн болон хэсэгчилсэн байдлаар шийдэн, авто замын сүлжээг сайжруулж, газар дээрх болон доорх авто зогсоолуудыг барих замаар түгжрэлийг бууруулж, нийтийн тээврийн шинэ үйлчилгээг нэвтрүүлнэ.



A handwritten signature in black ink, consisting of stylized cursive letters.

- 2.1. Гэр хорооллын айл өрхийг цахилгаан, эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбоно. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 2.2. Хөв цөөрөм байгуулж, байгалийн нөхөн сэргээлтийг бүрдүүлэхээс гадна иргэдийн ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлнэ. Уг ажлыг хэрэгжүүлэх хувийн хэвшлийг дэмжинэ. (Нийслэлийн төсөв)
- 2.3. Шинэ суурьшлын бүст бие даасан, хийн түлшээр ажилладаг, тархмал дулааны эх үүсвэрүүдийг байгуулна. (Улсын төсөв)
- 2.4. Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрхүүдэд 5кВт-ын суурилагдсан хүчин чадалтай нарны цахилгаан эх үүсгүүр суурилуулж агаар, хөрсний бохирдлыг бууруулна. (Улс, нийслэлийн төсөв)
- 2.5. Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг ашиглалтад оруулна. (Улсын төсөв)
- 2.6. Гэр хорооллын суурьшлын бүсийн усан сан, дамжуулах шугам сүлжээг шинээр барьж, зөөврийн ус түгээх барилгуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 2.7. Баянхошуу дэд төвийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн шинэчилж алдагдлыг бууруулж, тасралтгүй найдвартай ажиллагааг хангана. (Нийслэлийн төсөв)
- 2.8. Толгойт дэд төвийн коллектруудыг ашиглалтад оруулж хүртээмжийг нэмэгдүүлнэ. (Нийслэлийн төсөв)
- 2.9. Гэр хорооллын нийтийн тээврийн хүртээмжгүй бүсэд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлнэ. (Нийслэлийн төсөв)
- 2.10. Авто машины нүхэн гарцыг байгуулна. (Улс, нийслэлийн төсөв)
- 2.11. Орон сууцны хорооллын доторхи авто зам шинэчлэл, засварын ажлыг хийнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 2.12. Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд газар дээрх, газар доорх, автомат олон давхар, их багтаамжийн зэрэг бүх төрлийн авто зогсоолыг хувийн хэвшилтэй хамтран хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулна. (Улс, нийслэлийн төсөв)
- 2.13. Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Өнөр хорооллын гудамж замыг одоо байгаа зорчих хэсэг, явган хүний зам болон ногоон байгууламж, уулзваруудын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулж, ус зайлуулах системийг шинэчлэн сайжруулж цогц гудамж зам болгон хөгжүүлнэ. (Нийслэлийн төсөв)
- 2.14. Үерийн далан, ус зайлуулах шугамын өргөтгөл, шинэчлэлтийг хийнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)

### **ЗОРИЛТ 3. ЭДИЙН ЗАСАГ**

Дүүргийн татварын болон татварын бус орлогыг бүрдүүлэн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах замаар эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

- 3.1. Төсвийн төлөвлөлт, Орон нутгийн өмчийн менежментийг боловсронгуй болгоно. (Дүүргийн төсөв)
- 3.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээнд ээлтэй бодлого эрх зүйн орчныг сайжруулж, төрийн хяналт, шалгалтыг цөөрүүлнэ.
- 3.3. Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж бодлогоор дэмжинэ. (Улсын төсөв)
- 3.4. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх инкубатор төвийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ. (Нийслэлийн төсөв)

111714503  
УХА0012 9077273



- 3.5. Баянхошуу дэд төвд үндэсний хэв маяг хадгалсан гар урлал, жижиг дунд үйлдвэрлэл, уламжлалт эмчилгээ үйлчилгээний гудамж байгуулна. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 3.6. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөдөө аж ахуйн төрөлжсөн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд хувийн хэвшлийг дэмжин ажиллана. (Улс, нийслэлийн төсөв)
- 3.7. Бүсчилсэн хөгжлийн бодлого, Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд дүүргийн иргэдийг хямд чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 3.8. Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг дэмжиж, дүүргийн хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 3.9. Сүү, цагаан идээ үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр дагуул хотуудад хөгжүүлж, нэмэгдэл уураг, уургийн бэлдмэл зэрэг бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжийг бүрдүүлнэ.
- 3.10. Хүнсний ногоог хадгалах, борлуулах ажлыг шууд худалдааны борлуулалтын сүлжээ, төрөлжсөн захыг дэд төвүүдэд бий болгох замаар бүтээгдэхүүний тогтмол нийлүүлэлтийг бий болгоно. (Улс, нийслэлийн төсөв)
- 3.11. Хүнсний нарийн ногоо, жимс жимсгэнэ ургуулах хүлэмжийн аж ахуйг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлэх замаар иргэдийг жилийн 4 улирлын туршид эрүүл, аюулгүй хүнсээр хангах боломжийг бүрдүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 3.12. Төвлөрлийг бууруулах, автозамын ачаалал, бараа эргэлтийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хүрээнд тээвэр логистикийн терминалыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. (Улс, нийслэлийн төсөв)
- 3.13. Дүүргийн онцлогт тохирсон, түүх, археологи, нүүдлийн соёл, зан заншил, шашны биет болон биет бус түүх соёлын өв, байгалийн өвөрмөц байдлыг бүртгэлийн сан үүсгэж, нийтийн хүртээл болгон танилцуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно. (Дүүргийн төсөв)
- 3.14. Монгол Наадам цогцолборыг аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)

#### **ЗОРИЛТ 4. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

Хэт төвлөрөл, суурьшлын бүсийн тэлэлтээс үүдсэн хотын төв рүү тэмүүлсэн урсгалыг дэд төвүүд болон 4 хотыг хөгжүүлж, тухайн бүсэд ажлын байр, II шатлалын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төвүүдийг цогцоор байгуулж, тэгш хүртээмжийг бий болгоно. Залуусын хөгжлийг дэмжин чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлнэ.

- 4.1. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. (Улсын төсөв)
- 4.2. Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 4.3. Цэцэрлэгийн хоол болон ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны стандартыг шинэчилж, орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ. (Улсын төсөв)
- 4.4. Ерөнхий боловсролын сургуулийн хэрэгцээ өндөртэй байршилд хүн амын нягтаршил, өсөлт, хүртээмжийг үндэслэн гэрт хамгийн ойр сургууль барих

1117145633  
УХА0612 997278




- ажлыг шат дараатай хэрэгжүүлж, амьдарч буй орчиндоо чанартай боловсролын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 4.5. Багш нарын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайжруулж, гадаад дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 4.6. Хавдар судлалын үндэсний төв II байгуулна. (Улсын төсөв)
- 4.7. Шинээр байгуулах 4 хот тус бүрд одоогийн ӨЭМТ-ийг нэгтгэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 4.8. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих”, “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих”, “Халдварт өвчинтэй тэмцэх”, “Ахмадад ээлтэй дүүрэг”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Боловсролыг дэмжих” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. (Дүүргийн төсөв)
- 4.9. Халдварт бус өвчлөл, нас баралтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нийгмийн эрүүл мэндийн сайн дурын ажилтнуудыг бий болгож эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 4.10. Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцсэн байдлаар зохион байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ. (Дүүргийн төсөв)
- 4.11. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 4.12. Эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах замаар бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 4.13. Хүрээ соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг явуулах хувийн хэвшлийг дэмжинэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 4.14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг шинээр тавих зам харгуй, нийтийн тээвэр болон төрийн байгууллагуудад мөрдүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 4.15. Улсын Хүүхэд залуучуудын театр орчмыг залуучуудын бүс болгон кино театр, хөлбөмбөгийн талбай, спорт ордон барина. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 4.16. Хүүхэд, гэр бүлд чиглэсэн урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулж, хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 4.17. Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх соёл, урлаг, спортын олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулна. (Нийслэл, дүүргийн төсөв)

## **ЗОРИЛТ 5. НОГООН ХӨГЖИЛ**

Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна. Хог хаягдлын менежментийг хувийн хэвшилд шилжүүлж, үйлчилгээний хуваарийг иргэдэд саадгүй, илүү хүртээмжтэй болгоно. Нийслэлийн хэмжээнд хөрсний бохирдолгүй анхны дүүрэг болно.

- 5.1. Гэр хорооллын 20,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж хөрсний бохирдолгүй анхны дүүрэг болно. (Дүүргийн төсөв)
- 5.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, “Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-тэй уялдуулан 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)



Handwritten signature.



- 5.3. Гэр хорооллын айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжиж хөтөлбөр ажиллана. (Дүүргийн төсөв)
- 5.4. Баянхошуу, Нарангийн голын эргийн дагууд иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчинг нэмэгдүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 5.5. Өнөр бүсийн иргэдийн спортоор хичээллэх биеийн тамирын талбай байгуулна. (Дүүргийн төсөв)
- 5.6. Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг хангуулж, арчлалт үйлчилгээг эзэнжүүлснээр тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангана. (Дүүргийн төсөв)
- 5.7. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 5.8. Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд шилжинэ. (Дүүргийн төсөв)
- 5.9. Гудамж талбайн цэвэрлэгээ, хог ачиж цуглуулах үйлчилгээнд тусгай зориулалтын тоног төхөөрөмжтэй машин техникийг нэвтрүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 5.10. Дүүрэгт хог хаягдлыг хүлээн авч ангилан ялгах дундын бичил төвүүдийг бий болгож, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг арчлах хамгаалах иргэдийн бүлгийг ажиллуулна. (Нийслэл, дүүргийн төсөв)
- 5.11. Хог ангилах болон шатааж эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр байгуулна. (Улс, нийслэлийн төсөв)
- 5.12. Хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам, нүхэн гарц, бичил цэцэрлэгт хүрээлэн дэх гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 5.13. Гудамж талбайн камержуулалт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 5.14. Газрын төлөвлөлтийг боловсронгуй болгож суурьшлын бүс дэх иргэдийн амьдрах орчныг сайжруулна. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 5.15. Барилга, байгууламжийн орц гарцыг чөлөөтэй саадгүй болгож, хотын төв орчимд өндөр хашаа, хаалтыг буулгах, нам дор бут сөөгөн хашаажуулах бодлого хэрэгжүүлнэ. (Нийслэл, дүүргийн төсөв)

## **ЗОРИЛТ 6. ОРОН СУУЦНЫ ХҮРТЭЭМЖ**


Дэд төвүүдийг хөгжүүлж улмаар бизнес, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулан, бизнесийн идэвхжлийг дэмжих замаар орон сууцыг нэмэгдүүлж, дахин төлөвлөлтөд багтсан газрын үнэ цэнийг өсгөнө.

- 6.1. Гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлыг бууруулах хүрээнд амьдрах орчин, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, бизнесийн боломжийг нэгдсэн байдлаар төлөвлөсөн дэд төвүүдийг хөгжүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 6.2. Дэд төвд хүн амын хэрэгцээ шаардлагад тулгуурлан, ЕБС, цэцэрлэг, II шатлалын эмнэлэг барьж ашиглалтад оруулна. (Улс, нийслэлийн төсөв)
- 6.3. Баянхошуу дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж, орчин үеийн тохилог хороолол барина. (Улс, нийслэлийн төсөв)
- 6.4. "Орлогод нийцсэн ногоон орон сууц төсөл"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. (Улс, нийслэлийн төсөв)
- 6.5. Ногоон зээлийн санхүүжилтээр гэр хорооллын айл өрхүүдийн амины орон сууцны дулааны алдагдлыг бууруулна. (Улс, нийслэлийн төсөв)

1117145  
УХА05129



- 6.6. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасад шинэчлэх, дээврийн завсар, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ. (Улс, нийслэл, дүүргийн төсөв)
- 6.7. Гэр хорооллыг орон сууцжуулах бодлогын хүрээнд Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжих орон сууцны хөтөлбөрт газар чөлөөлөх ажлыг дэмжин хамтран ажиллана. (Нийслэл, дүүргийн төсөв)





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 №

987

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Сүхбаатар дүүргийн Монгол Ардын намын хорооны нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /.....<sup>6</sup>..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



**СҮХБААТАР  
ДУҮРГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРОО**

**СҮХБААТАР ДУҮРГИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНООС ДУҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Улаанбаатар хот  
2024 он

Сүхбаатар дүүргийн Монголын Ардын  
намын хорооны 2024 оны 06 дугаар сарын  
23-ны өдрийн IV хуралдаанаар хэлэлцүүлэн  
батлав.



## СҮХБААТАР ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Ардын намаас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/04 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”-ыг үндэслэл болгож, 2024 оны Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр тэр дундаа “20 минутын хот” засаглалын реформыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Ухаалаг, жишиг дүүрэг” уриаг дэвшүүлж, Сүхбаатар дүүргийн Монгол Ардын Намын Хорооноос сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хүргүүлж байна.

### “Хүнлэг Хурдан Хот” хөгжлийн хөтөлбөр

1. Нийгмийн хөгжлийг хурдасгана
2. Эдийн засгийн хөгжлийг хурдасгана
3. Амьдрах орчны хөгжлийг хурдасгана
4. Засаглалын хөгжлийг хурдасгана
5. Дэд төвийн хөгжлийг хурдасгана


гэсэн 5 зорилтын хүрээнд 76 заалт, “Их хотын түүх”, “Тухлаг хашаа, Дулаан сууц”, “Түрээсийн орон сууц”, “Миний ажилтан орон сууцтай”, “Саруул монгол”, “Кембрижийн хөтөлбөр” гэсэн 6 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр боловсрууллаа.

### 1.Нийгмийн хөгжлийг хурдасгана

#### 1.1.Боловсрол

- 1.1.1.Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүүхэд бүрийг 20 минутаас ихгүй зайд сургууль, цэцэрлэгт хүрэх боломжийг бий болгоно.
- 1.1.2.Төвийн сургуулийн математик, физик, хими, технологи (STEM) зэрэг байгалийн шинжлэх ухааны сонгоны ангийг сургууль бүрт байгуулна.
- 1.1.3.Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад Кембрижийн хөтөлбөрийг нэвтрүүлнэ.
- 1.1.4.Багш солилцооны хөтөлбөрийг бий болгох замаар боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.1.5.Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулна.
- 1.1.6.Сургуулиудын номын санг тохижуулан, цахим ур чадварын төв байгуулж бүх насны иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- 1.1.7.Сургуулиудад харааны чадавх шалгах булан байгуулж, өсвөр насны хүүхдүүдийн харааны согогоос урьдчилан сэргийлнэ.
- 1.1.8.Цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулж, шимт чанар бүхий хоолоор хангах боломжийг бүрдүүлнэ.

2



## **1.2.Эрүүл мэнд**

- 1.2.1.Өрхийн эрүүл мэндийн төвийн хүртээмж, чадамжийг нэмэгдүүлэн 20 минутын дотор эрүүл мэндийн нэн шаардлагатай үйлчилгээг хүргэх боломж бүрдүүлнэ.
- 1.2.2.Дүүргийн эрсдэлт бүлгийн нийт хүн амыг эрт илрүүлэгд бүрэн хамруулж, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулна.
- 1.2.3.Эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, эрүүл аж төрөх хэв маягийг хэвшүүлж, нийтийн биеийн тамир, спортын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.4.Нийтийн эрүүл мэндийг дэмжих Нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг байгуулна.
- 1.2.5.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулна.

## **1.3.Нийгмийн хамгаалал**


- 1.3.1 Ахмад настны чөлөөт цагаа хамтдаа, үр бүтээлтэй өнгөрөөх Ахмадын өргөөг байгуулна.
- 1.3.2 Дүүргийн соёлын ордныг байгуулна.
- 1.3.3 Өсвөр насны хүүхдүүдийг хорт зуршлаас сэргийлэх, эрүүл өсч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлсэн Соёл, спортын цогцолбор байгуулна.
- 1.3.4 Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, мэргэшүүлэх, чадавхжуулах, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг оршин суугчдын оролцоотойгоор хангуулж, арчлалт, засвар үйлчилгээг тогтмолжуулна.
- 1.3.6 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэтгэврээс гадуурх орлогыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3.7 Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах, жагсаал, цуглаан хийх зөвшөөрлийн тогтолцоог хална.
- 1.3.8 Сургуулийн орчинд хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх бүтээгдэхүүн үйлчилгээний чанар стандартыг хангах хяналтын тогтолцоог сайжруулна.
- 1.3.9 Ногоон бүс дэх хүүхдийн зусланг англи хэлний төрөлжсөн хөтөлбөртэй болгож, зуны болон өвлийн амралтаа бүтээлч байдлаар өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.3.10 “Саруул Монгол” архидан согтууруулахтай тэмцэх цогц хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.3.11 Төрийн байгууллагуудад хүүхэд хуурайлах, саатуулах өрөө бий болгоно.

## **2.Эдийн засгийн хөгжлийг хурдасгана**

### **2.1.Бизнес эрхлэхэд таатай орчин**

- 2.1.1.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй санхүүжилтийг бодлогоор дэмжиж, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бизнес инкубатор төвүүдийг байгуулна.
- 2.1.2.Бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хуульд тогтоомжид заасан хөнгөлөлтийг бизнес эрхлэгчдэд хүргэж, хуульд заасны дагуу хуулийн этгээд цахимаар байгуулж, төрөл бүрийн зөвшөөрлийг хиймэл оюуны тусламжтайгаар 2 цагт олгодог болно.

 3



- 2.1.3. Дүүргийн алсагдсан хэсгүүдэд нэн шаардлагатай үйлчилгээ болох эрүүл мэнд, боловсрол, спортын цогцолборуудыг Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу төр хувийн түншлэлд тулгуурлан байгуулж, ажлын байр нэмэгдүүлнэ.
- 2.1.4. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч ажиллана. (жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулдаг нэгдсэн зах, худалдааны төв байгуулна).
- 2.1.5. Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэнд эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн, иргэдийн ая тухтай байдлыг хангасан түргэн хоолны (street food) болон хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

## 2.2. Ажлын байрыг нэмэгдүүлнэ


- 2.2.1. Тусгай хэрэгцээт иргэн, ахмад настан, бага насны хүүхдээ гэртээ асардаг эцэг, эхчүүдийг ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.
- 2.2.2. Аж үйлдвэрийн 4-р хувьсгалтай хөл нийлүүлэн, дэлхийн зах зээлд ажил эрхлэхэд шаардлагатай цахим ур чадвар олгох мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн дэргэд байгуулна.

## 3. Амьдрах орчны хөгжлийг хурдасгана

### 3.1. Дэд бүтэц

- 3.1.1. Үерийн далан, ус зайлуулах шугамын өргөтгөл, шинэчлэлтийг хийж, усанд автдаг авто зам, явган замын тоог бууруулна.
- 3.1.2. Сэргээгдэх эрчим хүчинд ашигладаг эрчим хүчний хэмнэлттэй, ухаалаг гэрэлтүүлгийн сүлжээ байгуулна.
- 3.1.3. Дүүргийн хэмжээнд иж бүрэн камержуулалтыг шийдвэрлэж, камерын хяналтын нэгдсэн төвийг байгуулна.
- 3.1.4. Дүүргийн хэмжээнд хаягжилтыг стандартад нийцүүлэн, шинэчилнэ.
- 3.1.5. Саарал усыг ашиглах технологийг нэвтрүүлж, ашиглалтыг нэмэгдүүлэх замаар цэвэр усны хэрэглээг бууруулна.
- 3.1.6. Гэр хороолол дахь ундны усны худгийн тоог нэмэгдүүлж, түгээлтийн ухаалаг системийг сайжруулна.
- 3.1.7. Дүүргийн алслагдсан бүс хэсгүүдэд нийтийн тээврийн богино эргэлтийн чиглэл бий болгоно.
- 3.1.8. Гэр хорооллыг дэд бүтэцжүүлж, дүүргийн эдийн засгийг тэлэх шинэ боломжийг бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.9. Сэлбэ дэд төвийг түшиглэн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх орчныг бүрдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.1.10. Барилгын материал, авто засварын газруудад ариун цэвэр, орчны бохирдлын стандартыг мөрдүүлнэ.
- 3.1.11. Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан, тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг мөрдүүлнэ.
- 3.1.12. Шилэн кабелийг өрхүүдэд хүргэж, өндөр хурдны интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.








- 3.1.13. Гэр хорооллын бүсэд гал, утаа, үер усны мэдрэгч зэрэг төхөөрөмжүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагаанд тулгуурлан байршуулж, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалахад юмсын интернэтийг (IoT) ашиглана.
- 3.1.14. Дугуй, скүүтер болон явган хүний замыг олон улсын стандартын дагуу байгуулна.
- 3.1.15. Амралт, чөлөө цагаа өнгөрүүлэх ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангасан стандарт мөрдүүлнэ.
- 3.1.16. Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах менежментийг сайжруулах ухаалаг техник, технологийг нэвтрүүлнэ.
- 3.1.17. Дүүрэгт авто зогсоолын ухаалаг систем нэвтрүүлнэ.
- 3.1.18. Иргэдийн зорчих хөдөлгөөний хаасан, зөвшөөрөлгүй хашаа хайсыг буулгаж орц гарцыг чөлөөлж, намхан бут, сөөгөн хашаажуулах бодлого хэрэгжүүлснээр амьдрах орчиныг сайжруулна.
- 3.1.19. Иргэдийг эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцанд хамруулах чиглэлд дэмжлэг үзүүлнэ.


### 3.2. Тухлаг хашаа, дулаан сууц хөтөлбөр

- 3.2.1. Хашаа бүрт мод тарих зорилтыг дэвшүүлж, өрхийн тоогоор модтой, эко ногоон дүүрэг болно.
- 3.2.2. Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор байгальд ээлтэй эко, био 00-той “Тухлаг хашаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Дулааны алдагдлыг бууруулах технологийн шийдэл бүхий “Дулаан сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.2.4. Гэр хорооллын гудамж бүрт ухаалаг гэрэлтүүлэг бүхий явган зам байгуулна.
- 3.2.5. Гэр хороололд олон улсын “3 үгт” хаягжилтын нэвтрүүлж, гудамж бүрт шуудангийн үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлнэ.

### 3.3. Их Хотын түүх

- 3.3.1. Хуучны барилгуудын гадна фасад, дээвэр, цахилгаан сантехникийн сүлжээнд цогц засвар хийж сайжруулна.
- 3.3.2. Хотын төв хэсэгт барилгажилтын тусгай стандарт тогтоож, түүхэн уламжлалыг хадгалах талаар нийслэлийн болон бусад төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 3.3.3. Хотын соёлыг хөгжүүлэх зорилгоор өглөөний гудамж, жуулчны гудамжуудыг нэмж тохижуулан бичил бизнесийн орчин бүрдүүлнэ.
- 3.3.4. Төлөвлөгөө зөрчсөн, зөвшөөрөлгүй барьсан хашаа, барилгуудыг буулгаж нийтийн эдэлбэр газар болгон тохижуулна.
- 3.3.5. Дотоодын болон гадаадын жуулчдад зориулсан нийслэл хотын уламжлал, шинэчлэлийг танилцуулах тусгай хөтөлбөр бий болгоно.
- 3.3.6. Дамбадаржаалин хийдийг сэргээн засварлаж, хотын түүх, соёлын төвийг хамгаалан, төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- 3.3.7. Циркийн урлагийн хөгжлийг дэмжих зорилгоор 8-р хороонд байрлах циркийн хуучин байрыг сэргээж, хүүхдүүдэд зориулсан сургалтын төв байгуулна.
- 3.3.8. Сэлбэ гол дагасан амралт, зугаалга, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 3.3.9. Сэлбэ дэд төвийг түшиглэн Сүхбаатар дүүргийн нэрэмжит соёл, амралтын хүрээлэн байгуулна.

 5



#### 4. Засаглалын хөгжлийг хурдасгана

- 4.1. Төрийн үйлчилгээг либералчилж, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн, төвлөрлийг задалж, нэг цэгээс төрийн бүх үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэн, ХУРДАН цэгийг хороо бүрт байгуулна.
- 4.2. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх ухаалаг платформыг нэвтрүүлж “Шилэн дүүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг иргэдийн саналд үндэслэн шийдвэрлэнэ.
- 4.4. Дүүргийн засаг захиргааны байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээнд асуудлыг шийдвэрлэсэн байдал, иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийг тусгана.
- 4.5. Иргэдийн өдөр тутмын амьдралд нөлөөлөх аливаа шийдвэрийг урьдчилан тооцоолж, сэндбокст туршин, симуляц хийсний үндсэн дээр иргэдэд хүндрэлгүй иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан шийдвэрлэдэг хүндээ ээлтэй тогтолцоог бий болгоно.
- 4.6. Дүүргийн удирдлагууд, сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, Нийслэл, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчидтэй сар бүр тогтмол уулздаг “Иргэнтэй уулзах цаг” бий болгоно.
- 4.7. Гэрлэн дохиог хөдөлгөөний урсгал, явган зорчигчийн ачааллаас хамаарсан, хүнээс хамааралгүй, хиймэл оюун ухаанаар зохицуулдаг болгоно.

#### 5. Дэд төвийн хөгжлийг хурдасгана

- 5.1. Хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулж, иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор Сэлбэ, Дамбадаржаа дэд төвүүдийг түшиглэн, 20 минутын хот зарчмыг хэрэгжүүлсэн анхны жишиг дүүрэг болно.
- 5.2. Дэд төвүүдийг түшиглэн “20 минутын хот” зарчмын дагуу нийгмийн хэрэгцээт үйлчилгээ болох бүх шатны сургууль, цэцэрлэг, худалдаа үйлчилгээний цогцолбор, хүнсний зах, барааны ложистик төв, соёл, урлаг, спортын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахыг дэмжинэ.
- 5.3. Сэлбэ, Дамбадаржаа дэд төвийг түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах, “Түрээсийн орон сууц”, “Миний ажилтан орон сууцтай” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.4. “Шарга морьт” бүсэд хот орчмын аялал жуулчлалын бүсийг бий болгоно.
- 5.5. Сэлбэ голын үерийн аюулаас сэргийлсэн тохируулга бүхий хөв цөөрөм, усан санг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахыг дэмжинэ.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 983

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хан-Уул дүүргийн Монгол Ардын нам хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хан-Уул дүүргийн Монгол ардын нам хорооны Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хан-Уул дүүргийн Монгол Ардын нам хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Хан-Уул дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР




М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛЭН ОРОЛЦОХ ХАН-УУЛ ДҮҮРГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“20 МИНУТЫН ХОТ – ЭКО ХАН-УУЛ”**

**Нэг. Төрийн албаны зохион байгуулалт - 20 минутын хотын шилжилт**

- 1.1 Хан-Уул дүүргийн төвийн хороодын үйл ажиллагааг уялдуулж **Хан-Уул хот**, Яармагийн хороодын үйл ажиллагааг уялдуулж **Яармаг хот**, Нисэхийн, Алсын хороодын үйл ажиллагааг уялдуулж **Буянт-Ухаа хотын** зохион байгуулалтын бэлтгэлийг хангана.
- 1.2 Улаанбаатар хотын шинээр төлөвлөж буй 42 нэгжийн хүрээнд 120 мянгат, Зайсан, Ээрмэл, Яармаг, Арцат, Буянт—Ухаа орчмыг хорооллын зохион байгуулалтад шилжүүлэх бэлтгэл хангана.
- 1.3 Хот тосгон эрх зүйн байдлын тухай хуулийн /2024 онд батлагдсан/ хэрэгжилтийг эхлэх хүртэл хугацаанд Хан-Уул бүс, Яармаг бүс, Буянт-Ухаа бүсийн хороод хот нийтийн аж ахуйн, хөрөнгө оруулалтын асуудлыг тухайн засаг захиргааны нэгжийн удирдлага шууд өөрсдөө шийдвэрлэдэг, асуудлыг шийдвэрлэх эрхийг Дүүргийн Засаг даргаас шилжүүлэх зохион байгуулалтын аргуудыг хэрэглэнэ.
- 1.4 Анхан шатны нэгж дээр иргэний гаргаж буй хүсэлтийг бүсийн хэмжээнд шууд шийдвэрлэх зохион байгуулалтын аргуудыг хэрэглэнэ.
- 1.5 Төрийн баримт бичгийн үйлчилгээгээр хангах цахим үйлчилгээний хурдан цэгүүдийг иргэдэд ойрхон хүртээмжтэй байх зохион байгуулалт хийж ажиллуулна.
- 1.6 Өрхийн эмнэлгүүдийн зарим зохион байгуулалтуудыг нэгтгэж 2-3 хороодын дунд хэвтэн эмчлүүлэх боломж бүхий Эрүүл мэндийн төвүүдийг эмнэлгийн байраар хангана.
- 1.7 Нийтийн хэв журмын сахиулах ажлын хүрээнд дүүргийн аль ч цэгт цагдаагийн байгууллага дуудлага хүлээн авснаас хойш 5-15 минутад очих автомашинаар, тухайн нэгжид иргэн 10 минут явганаар очих боломжтой Цагдаагийн хэсгүүдийг байраар хангана.
- 1.8 “Зөв хүүхэд зөв ирээдүй” дэд хөтөлбөр, “Ахмаддаа дээдэлье” дэд хөтөлбөр, “Багш” дэд хөтөлбөр, “Залуус” дэд хөтөлбөр, “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөр, “Архигүй орчин” дэд, “Бүтээгч Хан-Уулчууд” дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.



1.9 "Е-Монголиа" шинэчлэлийг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад бүрэн нэвтрүүлж, иргэдийг хэрэглэх чадавхийг нэмэгдүүлэх сургалтийг хийнэ.

## Хоёр. Эко дүүрэг – Ногоон хөгжил, эрүүл мэнд, боловсрол, соёлын хөрөнгө оруулалт

### Ногоон хөгжил

2.1 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт бүхий тохижилтыг аргачлалыг нэвтрүүлж ногоон байгууламжийг хотхон, хороолол, СӨХ-ны хүрээнд нэмэгдүүлэх бодлого баримтлан шаардлагатай дэмжлэг үзүүлнэ

2.2 Иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх бичил болон цэцэрлэгт хүрээлэнгүүдийг 3 дахин нэмэгдүүлж аялал амралт зугаалгын төвүүдийг дэмжинэ.

2.3 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Айцын аман дахь мод тарилтыг эрчимжүүлж "Хан-Уул ойн төглийг" иргэдийн оролцоотой байгуулна.

### Эрүүл мэнд, спорт

2.4 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэнэ.

2.5 Өрхийн болон Эрүүл мэндийн төвүүдэд иргэдийг өдрийн эмчилгээгээр эмчлэх боломж бүхий зориулалтын тоног төхөөрөмж, өрөө тасалгаагаар хангаж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийг хагас жил тутам өдрийн эмчилгээнд хамруулна.

2.6 Хан-Уул спорт ордон, бүс тус бүрд спорт заал, сагсан бөмбөгийн 3x3 талбайг 500 метрийн радиус тутам, мини хөлбөмбөг, гүйлтийн талбайг 1 километрийн радиус тутам, байгуулна.


2.7 "Иргэдийн спортын наадам"-ийг улирал бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж спортлог хотууд болно.

### Боловсрол

2.8 Сургууль бүрд математик, физик, химийн төрөлжсөн танхимд хөрөнгө оруулалт хийж, багшийн чанарт анхаарч нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлнэ.

2.9 Сургуулиудын Англи, Солонгос хэлний сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дэмжлэг үзүүлнэ.

2.10 Цэцэрлэгийн хүүхдүүдийн урлагийн авьяасыг нээх, анги танхимыг сайжруулахад хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлнэ.



## Соёлын хөрөнгө оруулалт

- 2.11 Соёлын ордны үйл ажиллагааг өргөтгөн төрийн захиргааны анхан шатны нэгж болон Ерөнхий боловсролын сургуулийн байрнуудад тулгуурлан урлаг, соёлын дугуйлан секцийг нэмэгдүүлж, багшлах боловсон хүчнээр хангана.
- 2.12 Хан-Уул Соёлын ордны барилгыг дахин төлөвлөж 1000 хүний багтаамж бүхий соёл, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах боломж бүхий барилгыг барина.
- 2.13 Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох олон нийтийн аян өрнүүлнэ.

## Гурав. Дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт

- 3.1 Гэр хорооллын бүх гудамжийг зохист найрлага бүхий хучилттай болгож, жилд тогтмол 2 удаа сэргээн засвар хийгддэг зохион байгуулалтыг бий болгоно.
- 3.2 Зураг төсөв нь батлагдсан гэр хорооллын замыг хатуу хучилттай болгоно.
- 3.3 Бүх гэрэлтүүлгийн толгойг сайжруулах, гэрлийн шонгийн өнгө үзэмжийг сэргээх, засварлах, шинэчлэх.
- 3.4 Хог тээвэр, зам, хот нийтийн аж ахуйн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
- 3.5 Хог хаядаг хогийн савыг шинэчилнэ.
- 3.6 Гэр хорооллын хуучин хэлбэрийн жорлонг Эко шийдэл бүхий ариун цэврийн байгууламжийн хэлбэрт шилжүүлнэ.
- 3.7 Камержуулалтын тоог нэмэгдүүлж ногоон бүс хяналтын системийг хэрэгжүүлнэ.
- 3.8 Хотхон, хороолол дундах авто зогсоолыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийнэ.
- 3.9 Гэр хороолол болон орон сууцны хотхон хорооллын борооны ус тогтдог хэсгийн суваг шуудуу, зарим хэсэгт үерийн ус зайлуулах системийг хийнэ.
- 3.10 Авто замуудын ус зайлуулах хэсгийг засварлах, шинээр хийнэ.

-- 000 --





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 995

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Чингэлтэй дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,



Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Чингэлтэй дүүргийн Монгол Ардын намын хорооны Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Чингэлтэй дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /.....6..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Чингэлтэй дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**ИРГЭН ТӨВТЭЙ - АЮУЛГҮЙ ЧИНГЭЛТЭЙ**

**АГУУЛГА.**

Нэг. ИРГЭН ТӨВТЭЙ – ЧИНГЭЛТЭЙ

Хоёр. НИЙГМИЙН ХӨГЖИЛ- ХҮРТЭЭМЖТЭЙ ЧИНГЭЛТЭЙ

2.1 Боловсрол


2.2 Эрүүл мэнд

2.3 Нийгэм


Гурав. ГЭР ХОРООЛОЛ - БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Дөрөв. ИЛҮҮ ХУРДАН – УХААЛАГ ЧИНГЭЛТЭЙ

Тав. ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ – АЮУЛГҮЙ ЧИНГЭЛТЭЙ



**“ЧИНГЭЛТЭЙН СЭРГЭЛТ 2028” – ИРГЭН ТӨВТЭЙ, АЮУЛГҮЙ**  
**БҮСЧИЛСЭН ХОТ**




**Нэг. ИРГЭН ТӨВТЭЙ - ЧИНГЭЛТЭЙ**

- 1.1 Хүн амын зохистой харьцаа, төвлөрлийг харгалзан иргэд өөрийн гэрээс “20 МИНУТЫН ЗАЙ”-д нийгмийн болон төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2 Төр захиргааны төвийг Дэнжийн мянгад /9-р хороо/ байгуулна.
- 1.3 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр бие даасан бодлогыг хэрэгжүүлж, кластераар хөгжүүлнэ.
- 1.4 Төрийн үйлчилгээ, явган хүний зам, гарц, автобусны буудал, нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байдлаар шийдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй дүүрэг болно.
- 1.5 Хотын стандарт, хот төлөвлөлтийн дагуу газрын зөвшөөрөл олгох ажлыг хэвшүүлнэ.
- 1.6 Гадаадын улс орон, хот дүүргүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, соёл, спорт, боловсрол, эрүүл мэнд, гамшгийн эрсдэлийг бууруулах, ажиллах хүчний солилцоо зэрэг нийгмийн бүхий л салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлнэ.
- 1.7 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшил дэх тоглоомын талбайн стандартыг мөрдүүлэн, хөдөлгөөний аюулгүй байдал, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөж, хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн “хүүхдэд ээлтэй” дүүрэг болно.
- 1.8 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Хоёр. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ХҮРТЭЭМЖТЭЙ ЧИНГЭЛТЭЙ**

**2.1 Боловсрол:**

- 2.1.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгч нарыг зөөврийн компьютероор бүрэн хангаж, цахим хичээл, алсын зайн сургалт явуулах нөхцөлийг нэмэгдүүлнэ.
- 2.1.2 Сургуулийн өмнөх боловсролын салбарт Олон улсын I'm brick, Steam, Montessori зэрэг хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн бүрэн хэрэгжүүлнэ.
- 2.1.3 Ерөнхий боловсролын сургуулиудад цахим хичээл, гадаад хэлний танхимуудыг байгуулж, Олон улсын сургалтын хөтөлбөрүүдэд хамруулна.
- 2.1.4 Ерөнхий боловсролын сургуулиудад орчин үеийн стандартын дагуу усан бассейн бүхий спорт сургалтын цогцолборыг үе шаттайгаар байгуулж, сургууль цэцэрлэгийн чанар, хүртээмжийг сайжруулна.
- 2.1.5 Шинжлэх ухааны хүрээлэнгүүдтэй хамтран ажиллаж, боловсрол, шинжлэх ухааны шинэ инновацыг нэвтрүүлнэ.
- 2.1.6 Боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх замаар багш, оюутан, сурагч солилцоог нэмэгдүүлнэ.
- 2.1.7 Багш нарын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалтад хамруулж, сургууль хоорондын боловсролын чанарын ялгааг арилгана. Цэцэрлэг, сургуулийн (үдийн) хоолны менежментийг сайжруулна. Хүүхэд бүрийг эрүүл хүнсээр хангах эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотой хяналтын системийг бий



## 2.2 Эрүүл мэнд:

- 2.2.1 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих чиглэлээр нийтийн биеийн тамираар хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлж, спорт зал, гадна биеийн тамирын талбайн хүртээмжийг сайжруулна.
- 2.2.2 Олон улсын стандартад нийцсэн дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулна.
- 2.2.3 Дүүргийн Нэгдсэн эмнэлэг /шинэ өргөтгөл/-ийг түшиглэн “Амаржих газар” болон “Хүүхдийн эмнэлэг”-ийг байгуулна.
- 2.2.4 Ахмад настны эрүүл мэндийг сайжруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Ахмад настны хэвтэн эмчлүүлэх тасгийг байгуулна.
- 2.2.5 Ахмад настны амралт, сувиллын газрын үйл ажиллагааг өргөжүүлж, ахмад настанд чиглэсэн цогц үйлчилгээг хэрэгжүүлж, Ахмадуудад ээлтэй дүүрэг болно.
- 2.2.6 Цахим шилжилтийн хүрээнд эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх “Мэдээллийн нэгдсэн сан” бий болгоно.
- 2.2.7 Дүүргийн болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад хамтын ажиллагаатай хот, дүүргийн эрүүл мэндийн салбарын ажлаар туршлага судлуулж, орон нутагтаа хэрэгжүүлнэ.
- 2.2.8 Япон улстай хамтран Ерөнхий боловсролын 37, 50 дугаар сургуулиудад хэрэгжүүлж буй “Эрүүл шүд” төслийг бусад сургуулиудад үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.2.9 “Эрт илрүүлэг” оношилгооны төвийн барилга, Хайлааст салбарын Амбулаторийн барилгыг бүрэн ашиглалтад оруулна.
- 2.2.10 Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг, оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.

## 2.3 Нийгэм

- 2.3.1 Чингэлтэй хайрхныг түшиглэн иргэдийн алхах, ая тухтай амарч зугаалах, аялал жуулчлалын бүс бий болгоно.
- 2.3.2 Сургуулийн өмнөх боловсрол, бага сургуулийн цогцолборуудыг “Сургууль”, “Цэцэрлэг”-ээр нь төрөлжүүлэн ангилж, сурагчдын ая тухтай, стандарт орчинд сурч, хөгжих боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.3 Ахмад настнуудад зориулсан сургалт, судалгааны төвийг байгуулах замаар ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.4 Дүүргийн “Угийн бичгийн танхим”, “Шагайн харвааны танхим”-ын үйл ажиллагааг өргөжүүлж, хороодын Иргэний танхимыг иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх жишиг танхим болгон тохижуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.
- 2.3.5 Залуус хөгжлийн төв, Гэрлэх ёслолын танхим бүхий дүүргийн Соёлын ордныг барьж, ашиглалтад оруулахын зэрэгцээ соёл урлагийн салбарыг бүх талаар дэмжиж, бие даасан чадамжтай болгоно.

- 2.3.6 Дүүргийн онцлогт тохирсон түүх, соёл, зан заншил, шашны биет болон биет бус өв, байгалийн өвөрмөц байдал болон нүүдлийн соёлыг танилцуулах аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.3.7 Олон үндэстэн угсаатны ардын язгуур урлагийг түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төвийн үйл ажиллагааг шинэчилнэ.
- 2.3.8 Гадаадын хотуудад түүх, соёл, үндэсний онцлогоо танилцуулах ажлыг идэвхжүүлнэ.
- 2.3.9 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хүрээнд “Спорт цогцолбор”-уудыг үе шаттайгаар байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.
- 2.3.10 Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийг шинээр байгуулна.
- 2.3.11 Гадаад улсын найрамдалт харилцаат хотуудтай хамтарсан гарааны бизнесийг дэмжих “Инновацын төв” байгуулна.
- 2.3.12 Хүүхэд хөгжлийн цогцолборыг өргөтгөх ажлын хүрээнд хүүхдийн зусланг шинээр байгуулна.
- 2.3.13 Оюутан, залуусын хөгжлийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүний нөөцийн зохистой бодлого баримтална.
- 2.3.14 Залуучууд бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого баримтлан ажиллана.
- 2.3.15 Идэвхтэй бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.3.16 Эмэгтэйчүүдийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, хамгааллын чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.17 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр хөтөлбөр, төслүүдийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.3.18 Хүлэмжийн аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжийн газрын төлбөрийг хөнгөлж, таримал ургамлын үр үржүүлэг, судалгаа шинжилгээний ажилд төрөл бүрийн дэмжлэг үзүүлнэ. Тариаланчид, ногоочдын бүтээгдэхүүнийг дундын зуучлалгүй шууд борлуулах цэгүүдийг нэмэгдүүлнэ.

### Гурав. ГЭР ХОРООЛОЛ – БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

- 3.1 Дэд төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар Чингэлтэй хотыг хөгжүүлнэ. (Сэлбэ, Дэнжийн мянга төв)
- 3.2 Дэд төвүүдийн төслийг Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийг дэмжих замаар гэр хорооллын дахин төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.3 Дүүргийн нутаг дэвсгэр дэх Таван буудал, Хайлааст, Чингэлтэй, Дэнжийн мянга орчмын газар чөлөөлөлтийг үргэлжлүүлж, орон сууцжуулах бодлого баримталж агаар, орчны бохирдлыг бууруулна.
- 3.4 Дэд төвд хүн амын хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургууль, цэцэрлэг, хүнсний зах, худалдааны төвүүдийг байгуулна.
- 3.5 Гэр хорооллын алслагдсан хороодод хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийг бий болгох замаар хөрсний бохирдлыг бууруулна.

- 3.6 Айл өрх, аж ахуйн нэгжийн хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжин урамшуулах замаар иргэд, хувийн хэвшлийн оролцоотойгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 3.7 Хотын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх өнгө үзэмжийг сайжруулах ажлыг үе шаттайгаар хөгжүүлэх ба хүүхэд залуучууд, ахмад настнууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бичил цэцэрлэгт хүрээлэнг хороо бүрд шинээр барьж байгуулна.
- 3.8 Хотын өнгө үзэмжийг сайжруулах, Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасад, дээвэр шинэчлэх, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 3.9 Нийтийн байрны орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд төр, хувийн хэвшил, оршин суугчдын оролцоотойгоор дахин барилгажуулна.
- 3.10 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч, дэд бүтэц, тохижилт, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.
- 3.11 Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн буюу саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ.
- 3.12 Хог хаягдлыг хүлээн авч ангилан ялгах дундын бичил төвүүдийг байгуулж, хог хаягдлыг дахин боловсруулах замаар эдийн засгийн эргэлтэд үе шаттай оруулна.
- 3.13 Авто зам, замын ус зайлуулах шугам сүлжээний шинэчлэлийн ажлыг эрчимжүүлнэ.
- 3.14 Шинэ тойрог замын сүлжээнд хороодыг холбох туслах замыг үе шаттай барьж байгуулна.
- 3.15 Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд газар дээрх болон доорх зогсоолыг төр хувийн хэвшлийн хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулах ажлыг эрчимжүүлнэ.
- 3.16 Гэр хорооллын дундах авто замыг өргөтгөн шинэчилж, нийтийн тээврийн автобусыг зорчих боломжийг бүрдүүлэн иргэдэд үйлчлэх чиглэлийг нэмэгдүүлнэ.
- 3.17 Нийтийн тээврийн чанар хүртээмжийг сайжруулж орчин үеийн тохилог, ухаалаг, дулаан автобусны буудлыг үе шаттайгаар байгуулна.
- 3.18 Гэр хорооллуудад хотын стандартад нийцсэн дугуйн замуудыг үе шаттайгаар барьж байгуулна.


#### **Дөрөв. ИЛҮҮ ХУРДАН - УХААЛАГ ЧИНГЭЛТЭЙ**

- 4.1 Засгийн газрын Цахим шилжилтийн хүрээнд төрийн цахим үйлчилгээг хороо бүрд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 4.2 Зөвшөөрөл зайлшгүй шаардах үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай эрхийг цахимаар шууд олгодог болно.
- 4.3 "IoT" камер, хэмжилтийн мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулах, хотын хөдөлгөөн, бохирдол, эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй авч анализ хийдэг, зохицуулах арга хэмжээ авдаг системийг хөгжүүлнэ.
- 4.4 Гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэл гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай шинэчлэх арга хэмжээ авна.

- 4.5 Ногоон бүс-камерын хяналтын системийг ухаалаг болгон, хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлж, зөрчил, гэмт хэргээс сэргийлэн аюулгүй найрсаг дүүрэг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.
- 4.6 Төрийн цахим үйлчилгээний 24 цагийн ухаалаг өөртөө үйлчлэх төвүүдийг нэмэгдүүлнэ.
- 4.7 Төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт явуулын цэгийг байгуулж, алслагдсан хороодод хүргэнэ.

#### **Тав. ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ - АЮУЛГҮЙ ЧИНГЭЛТЭЙ**

- 5.1 Хүн ам олноор суурьшсан нутаг дэвсгэрт, барилгын норм, дүрэм стандартад нийцсэн гал түймэр унтраах, аврах ангийг шинээр байгуулж, иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 5.2 Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулж, инновацыг ашиглах замаар гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлнэ.
- 5.3 Хороодын гамшгийн үеийн бэлэн байдал, урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлж, авран хамгаалах орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган, гамшгаас хамгаалах иргэдийн сайн дурын бүлгийг бүх талаар сургаж ажиллана.
- 5.4 Гал унтраах ангийн дэргэд иргэдийн сайн дурын мэргэжлийн тасаг үүсгэн байгуулж, гал унтраах, авран хамгаалах тоног төхөөрөмж, машин техникээр хангана.
- 5.5 Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, газ болон тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлын стандартыг мөрдүүлж хяналтыг сайжруулна.
- 5.6 Үерийн гамшгаас сэргийлэх ажлын хүрээнд усны барилга байгууламжийг үе шаттайгаар аюулгүйн стандартын дагуу барьж байгуулах, засварлан шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.7 Дүүргийн “Ногоон бүс” камерын хяналтын төвийн программ хангамжийг хөгжүүлж, яаралтай түргэн тусламж, гал, осол гамшиг, цагдаагийн дуудлагыг шуурхай хүлээн авч дүн шинжилгээ хийх нөхцөл байдлыг алсын зайнаас хянах “УХААЛАГ УДИРДЛАГЫН ТӨВ” болгон өргөжүүлнэ.



----000----



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 978  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАГАНУУР ДҮҮРГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Багануур дүүргийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,



Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Багануур дүүргийн Монгол Ардын нам нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багануур дүүргийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /...<sup>10</sup>... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Багануур дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийслэлийн Багануур дүүргийн Монгол Ардын Намын  
хорооны 13 дугаар хуралдааны 2024 оны 06 дугаар сарын  
22-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт



**БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
БАГАНУУР ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС  
ДЭВШҮҮЛЖ ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“БАГАНУУР ХОТЫН СЭРГЭЛТ”**


**1. БИДНИЙ ХОТ**

**1.1. Орон сууцны хүртээмж**

- 1.1.1. Иргэд хотын ойрын болон хэтийн төлөвлөлтөд оролцох боломжийг бүрдүүлж, төлөвлөлттэй уялдсан төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.1.2. Гэр хорооллыг орон сууцжуулах, орон сууцны хорооллыг тэлэх бодлогын хүрээнд 2000-аас доошгүй айлын орон сууцны хорооллыг барьж байгуулна.
- 1.1.3. Гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн шугамд холбох нэгдсэн зураг төслийг хийж, холболтын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.1.4. “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.1.5. Монгол гэр, хувийн сууцандаа сэргээгдэх эрчим хүч ашиглаж байгаа гэр хорооллын өрхийг дэмжин хамтран ажиллана.

**1.2. Эрчим хүч, дулаан хангамж**

- 1.2.1. 400МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барина.
- 1.2.2. Эрчим хүчний системийн оргил ачааллыг хөнгөлөх зорилго бүхий 50МВт цахилгаан эрчим хүч хуримтлуулах хүчин чадалтай батарей станцыг барьж ашиглалтанд оруулна.
- 1.2.3. Хотын суурьшлыг тэлэх, орон сууц, гэр хорооллын зарим хэсгийг цахилгаан эрчим хүчинд холбох, найдвартай ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 6кВ цахилгаан хуваарилах байгууламж 2, 6/0.4кВ дэд өртөөг 10-аас доошгүйг барьж байгуулна.





1.2.4. Хотын ерөнхий төлөвлөлтийн дагуу дулааны шугам сүлжээ, цахилгаан дамжуулах шугам сүлжээг нэмэгдүүлнэ.

### **1.3. Ус хангамж, ариутгах татуурга**

- 1.3.1. Орон сууцны хорооллын цэвэр усны шугам сүлжээг бүрэн шинэчилнэ.
- 1.3.2. Хотын ерөнхий төлөвлөлтийн дагуу цэвэр, бохир усны шугам сүлжээг нэмэгдүүлж, аж ахуйн нэгж, айл өрхийг холбоно.
- 1.3.3. Хоногт 10000м<sup>3</sup> бохир усыг цэвэрлэх хүчин чадалтай стандартад нийцсэн цэвэрлэх байгууламжийг барих ажлыг эхлүүлнэ.
- 1.3.4. Гэр хорооллын айл өрхүүдийг стандартад нийцсэн, байгаль орчинд ээлтэй нүхэн жорлонтой болгох ажлыг үргэлжлүүлнэ.
- 1.3.5. Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг ашиглах технологийг нэвтрүүлж, дэд бүтцийн шугам сүлжээг байгуулж эхэлнэ.

## **2. ХҮРТЭЭМЖТЭЙ ХОТ**

### **2.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж**

- 2.1.1. 2-5 насны хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулахыг зорьж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд байлган цэцэрлэгийн орны тоог 400-аар нэмэгдүүлнэ.
- 2.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн суралцах орчин нөхцлийг сайжруулах ажлыг үргэлжлүүлж, анги танхимын ширээ сандлыг эргономик байдлаар бүрэн шинэчилж, ухаалаг технологи бүхий ангийн тоог үе шаттай нэмэгдүүлнэ.
- 2.1.3. Эрэлт, хэрэгцээнд тулгуурлан нэн шаардлагатай мэргэжлээр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд гадаад дотоодын Мэргэжлийн боловсролын сургуультай хамтран олон талт төсөл хэрэгжүүлнэ.
- 2.1.4. Хүн амын нягтаршил, өсөлт, хүртээмжийг үндэслэн сургуулийн суудлын тоог 640-өөр нэмэгдүүлж, боловсролын чанар хүртээмжийг сайжруулна.
- 2.1.5. Сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг эрс нэмэгдүүлнэ.
- 2.1.6. Хүүхэд харах үйлчилгээнд дэмжлэг үзүүлж, хүүхдийн өдөр өнжүүлэх төвийг (нийтийн төв, community center) иргэдийн хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулна.
- 2.1.7. Цэцэрлэгийн хоол, сурагчдын үдийн хоолны илчлэг, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчлэхэд анхаарч төсвийг нэмэгдүүлнэ.



- 2.1.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт хотын соёл, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.
- 2.1.9. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг гадаадын нэр хүндтэй их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ.

## **2.2. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж**


- 2.2.1 4, 5 дугаар хорооны иргэдэд үйлчлэх өрхийн эрүүл мэндийн төвийг байрыг ашиглалтанд оруулж, эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 2.2.2 Эрүүл мэндийн төвийн орчин нөхцлийг сайжруулах их засварын ажлыг бүрэн хийж, эмнэлгийн шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж ажиллана.
- 2.2.3 “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.
- 2.2.4 Ерөнхий боловсролын сургуулиудад болон ЕБС-д шүдний кабинет байгуулж, төр хувийн хэвшилтэй хамтран “Эрүүл шүд” хөтөлбөрийг эрчимжүүлнэ.
- 2.2.5 Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.

## **2.3. Нийгмийн хамгаалал**

- 2.3.1. Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг худалдаа, үйлчилгээ, нийтийн тээвэр, төрийн байгууллагуудад мөрдүүлж, шинээр тавигдах авто болон явган зам, талбайн зураг төсөлд тусгайлан тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх танхимын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, төрөл бүрийн сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулж ажиллана.

### **Хүүхэд**

- 2.3.4. Тэмүүлэл хүүхдийн зусланд орчин үеийн стандарт шаардлага хангасан орчин нөхцлийг бүрдүүлж, хүүхдийн хүмүүжил, сурах арга барилыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулна.



- 2.3.5. Хүүхдийн эрхийг хамгаалах, хорт буруу зуршлаас ангид байх, соён гэгээрүүлэх төрөл бүрийн төсөл, хөтөлбөрийг олон улсын байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3.6. Хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлж ажиллана.
- 2.3.7. Хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх оюун ухаан, урлаг, спорт, гадаад хэлний төрөл бүрийн дугуйлан секцүүдийг иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэмэгдүүлнэ.

### **Залуучууд**

- 2.3.8. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх инкубатор төвийг байгуулна.
- 2.3.9. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, наадмын талбайн газарт хоккей, хөлбөмбөг, сагсан бөмбөг, воллейбол, хөнгөн атлетик, морин тойруулга, байт харваа, спорт буудлага, ногоон байгууламж бүхий тамирчдын бэлтгэлийн баазтай спорт цогцолборыг барьж байгуулна.
- 2.3.10. Монгол Улсын их, дээд сургуулийн салбар байгуулахыг бодлогоор дэмжинэ.

### **Ахмад**

- 2.3.11. Нарийны аманд ахмад настанд үйлчлэх амралт, сувиллын төвийг барьж байгуулна.
- 2.3.12. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.3.13. Ахмад настанг дэмжих төвийн гадна орчны тохижилтыг бүрэн хийж, иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх, хий бясалгал, нийтийн бүжиг хийх нөхцлийг бүрдүүлж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

### **Гэр бүл**


- 2.3.14. Орон сууцны эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан орчин үеийн тохилог орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.3.15. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлж, хүүхэд, гэр бүл хамгааллын байрыг ашиглалтанд оруулна.
- 2.3.16. Өөр хөдөө орон нутагт ажилладаг, малчин өрхийн бага насны хүүхдүүдийг 24 цагийн цэцэрлэгт хамруулах бодлогыг барьж ажиллана.



- 2.3.17. Цахим технологийг ашиглан эцэг, эх, асран хамгаалагч нар хүүхдийн цахим орчны хандалт, хараа хяналтгүй цаг хугацаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлж, буруу зуршил, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох эрсдлийг бууруулна.
- 2.3.18. Архины хамааралтай, орон гэргүй, тэнэмэл иргэдийг эрүүлжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийгмийн хамгааллын тусгай төвтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3.19. Төрийн өмнөөс гүйцэтгэж болох ажил болон зарим хяналт, шалгалтыг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3.20. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлогыг бүх талаар дэмжин спортын болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

#### **2.4. Авто зам, нийтийн тээврийн үйлчилгээний хангамж**

- 2.4.1. Багануур дүүргийн 10км тойрог автозамыг ашиглалтанд оруулж, төв замын хөдөлгөөний ачааллыг бууруулна.
- 2.4.2. Соронзын уулзвараас Гандан хүртэлх автозам, 4-р хорооноос ЖДҮДТ-ийн автозам, Ахицын уулзвараас Тогос уул хэсэг хүртэлх автозам, Шунхлай ШТС-аас Төмөр зам хүртэлх автозамыг бүрэн шинэчилж, орон сууцны хороолол дундах авто болон явган замыг бүрэн шинэчилнэ.
- 2.4.3. Мянганы замын уулзвараас Магнай трейд ШТС хүртэлх автозамын эгнээг өргөтгөж, Сургалтын задгай хэсгийн дундах автозам, Нугын тал хэсгийн дундах автозам, Баялаг хорооллын автозам, Уурхайчин хорооллын автозам, 84, 92, 96, 102 дугаар байрыг холбосон автозам, Титэм, Мандал хотхоны автозам, Хилчин, Замчин хэсэгт автозамыг шинээр тавина.
- 2.4.4. 81, 86, 102 дугаар байр, 2, 4, 5-р хорооны урд хэсэгт автозогсоолыг шинээр байгуулна.
- 2.4.5. Иргэд ихээр зорчдог хэсгүүдийн нийт 25 байршилд явган зам, талбайг шинэчлэн, Тогос уул, Төмөр зам хүртэл 4.4 км дугуйн замыг шинээр барина.
- 2.4.6. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, цагийн хуваарийг дахин төлөвлөж, хүртээмжтэй байдлаар шийдвэрлэнэ.
- 2.4.7. Гэр хорооллын болон орон сууцны хорооллын автобусны буудлын оновчтой төлөвлөлтийг шинэчлэх болон шинээр байгуулна.
- 2.4.8. Хот хоорондын зорчигч тээврийг иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шийдвэрлэж, хөрш зэргэлдээ Төв аймгийн Баяндэлгэр, Мөнгөнморьт сум,



Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдад баталгаат нийтийн тээврээр үйлчлэх боломжийг бүрдүүлнэ.



### 3. НОГООН ХОТ

#### 3.1. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал

- 3.1.1. “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, чанарын хяналт удирдлагын тогтолцоог сайжруулж, гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 3.1.2. Бүсчилсэн хөгжлийн бодлого, Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд малын биржээр дамжуулан хотын иргэдийг хямд чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.3. Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг дэмжиж, хотын хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.4. Сүү, цагаан идээ үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлж, иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангана.
- 3.1.5. Эрчимжсэн аж ахуй эрхлэх зориулалттай бүс нутгийн хил заагийг тогтоож хөдөө аж ахуйн төрөлжсөн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд хувийн хэвшлийг дэмжинэ.
- 3.1.6. Хүнс, нарийн ногоо, жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүний хадгалалтын нийт 1,000 тн багтаамжтай агуулах, хүлэмжийн аж ахуйг барьж байгуулан хотыг эрүүл, баталгаатай хүнсээр улирлаас үл шалтгаалан хангахад төр хувийн түншлэлээр шийдвэрлэж ажиллана.
- 3.1.7. Мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах орчин үеийн стандартын шаардлага хангасан үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэн, суурьшлын бүсэд амьд мал оруулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх арга хэмжээг авна.
- 3.1.8. Эрүүл ахуйн чанар стандартыг хангасан мал нядалгааны газрыг байгуулж, хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

#### 3.2. Ногоон байгууламж

- 3.2.1. Хотын ногоон байгууламжийг төрөлжүүлж, гэр хорооллын алслагдсан хэсгүүдэд иргэд амарч, тухлах ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэнтэй болгоно.
- 3.2.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран 1 сая мод, бут сөөгийг тарьж эко орчныг нэмэгдүүлнэ.



3.2.3. Айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг урамшуулан, мод ургуулах дадлыг бий болгох арга замаар дэмжиж ажиллана.

### **3.3. Агаар, хөрсний бохирдол**

3.3.1. Ундны усны шугамыг зэс хоолойгоор солих судалгаа хийж, усны зэвийг арилгах зорилгоор цэвэр усны шугамыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.

3.3.2. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

3.3.3. Гэр хорооллыг орон сууцжуулах, цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах замаар нүхэн жорлонгийн тоог бууруулж, хөрсний бохирдлыг бууруулах стандарт, нөхөн сэргээх, ногоон байгууламжуудыг бий болгох ажлыг иргэдийн оролцоотойгоор цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.

3.3.4. Ногоон зээлийн санхүүжилтээр гэр хорооллын айл өрхүүдийн амины орон сууцны дулааны алдагдлыг бууруулах бодлого баримталж сууцаа дулаалах, утаагүй халаалтын хэрэгсэлд шилжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

### **3.4. Хог хаягдлын менежмент**

3.4.1. Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд шилжинэ.

3.4.2. Дахин боловсруулах боломжтой хаягдал буюу дахивар цуглуулж тээвэрлэх тусгай хуваарьтай тээврийн үйлчилгээг хувийн хэвшилтэй хамтран нэвтрүүлнэ.


3.4.3. Хог хаягдлыг хүлээн авч ангилан ялгаж, бүтээгдэхүүн гаргах бичил төвийг бий болгоно.

## **4. ОРЛОГОТОЙ ХОТ**

### **4.1 Хотын төсвийн орлогыг дээшлүүлнэ**

4.1.1 Улсын зэрэглэлтэй хотын дагалдах эрх зүйн болон төсвийн баримт бичгүүдэд тусгах саналыг боловсруулж, хууль тогтоох дээд байгууллага, гүйцэтгэх засаглалтай хамтран ажиллана.

4.1.2 Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд хотын хүн амыг өсгөх, зах зээлийг тэлэх орон сууц, нийгэм, дэд бүтцийн нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтад онцгой анхаарч, хэрэгжилтийг хангана.








- 4.1.3 Үйлдвэр, технологийн парк, дулааны цахилгаан станц зэрэг томоохон татвар төлөгчийн тоог нэмэгдүүлэх замаар татварын орлогыг сайжруулж, хотын тулгамдсан асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэж ажиллана.
- 4.1.4 “Багануурын нүүрс-химийн цогцолбор” аж үйлдвэрийн паркийг байгуулах замаар үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байрыг бий болгоно.
- 4.1.5 Олон улсын тээвэр логистикийн төвийг байгуулж, гадаад худалдааг дэмжин ажиллана.

#### **4.2 Хувийн хэвшлийг дэмжинэ**

- 4.2.1 Стандартад нийцсэн хүртээмжийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгаж, иргэд бизнес эрхлэх орчинг сайжруулж, зөвшөөрлийн тогтолцооноос стандарт хангасан тогтолцоонд шилжих эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 4.2.2 Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, стандарт хангасан бүтээгдэхүүнийг борлуулахад хотын зүгээс сургалт, сурталчилгаанд анхаарч, зах зээлээ өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлнэ.
- 4.2.3 Ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэгийг байгуулж, цахилгаан бараа засвар, гутал, цаг засвар гэх мэт үйлчилгээг орон сууцнаас гарган стандарт үйлчилгээ үзүүлэхэд чиглэж ажиллана.
- 4.2.4 Үйлдвэрлэл технологийн паркийн дэргэдэх үйлдвэрүүдийг түшиглэн түүхий эд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, байнгын тогтвортой ажлын байрыг бий болгоно.

#### **4.3 Хотын соёл, урлаг, аялал жуулчлал**

- 4.3.1 Иргэдийг хотын соёлд суралцах, зөв үйл, дадлыг бий болгох соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, хотын соёлыг дээшлүүлнэ.
- 4.3.2 Багануур хотын музейг шинээр барьж байгуулна.
- 4.3.3 Иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэх 850 хүний суудалтай соёлын ордны барилгыг ашиглалтанд оруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд одоогийн соёлын ордныг кинотеатр болгоно.
- 4.3.4 Хотын нутаг дэвсгэр дэх түүх, археологи, нүүдлийн соёл, зан заншил, шашны биет болон биет бус түүх соёлын өв, байгалийн өвөрмөц байдлын бүртгэлийн





сан үүсгэж, нийтийн хүртээл болгон танилцуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.

- 4.3.5 Байгалийн тогтоц, түүх соёлын биет өв бүхий газрын аялал жуулчлалын маршрутыг хөрш зэргэлдээ сум, хувийн хэвшлүүдтэй хамтран бий болгон дотоодын болон гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.


## 5 АЮУЛГҮЙ ХОТ

### 5.1. Хүрээлэн буй орчны оновчтой төлөвлөлтөөр аюулгүй байдлыг хангана

- 5.1.1 Барилга, байгууламжийн орц гарцыг чөлөөтэй саадгүй болгож, өндөр хашаа, хаалтыг буулгаж, нам дор бут сөөгөн хашаажуулах бодлого хэрэгжүүлснээр амьдрах орчинг сайжруулна.
- 5.1.2 Хүүхдийн тоглоомын талбай, гудамж, явган хүний зам, нүхэн гарц, бичил цэцэрлэгт хүрээлэн дэх гэрэлтүүлэг, камержуулалтыг эрснэмэгдүүлж, ногоон бүс болгоно.
- 5.1.3 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, агаар сэлгэгч болон цэвэршүүлэгчийн систем нэвтрүүлж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 5.1.4 Гэмт хэргийн эрсдэл өндөртэй байршлуудад иргэдийн саналаар ухаалаг камер, автомат дугаар уншигч, эргүүлийн дрон зэрэг дэвшилтэт технологийг ашиглана.

### 5.2 Инновац, хиймэл оюун ухаан, цахим технологи

- 5.2.1 Эрүүл аюулгүй орчныг бий болгох зорилгоор гудамж, зам талбай, олон нийтийн газрыг бүрэн камержуулж, телекамерын хяналтын дэд төвийг бий болгоно.
- 5.2.2 Нийтийн тээвэр, шугам сүлжээний тасралт, саатлын мэдээлэл, хотын бохирдол, гамшиг осол, аюулгүй байдлын мэдээллийг иргэд, байгууллагад цаг алдалгүй мэдээлэх "IoT" камер, мэдрэгч төхөөрөмжүүдийг суурилуулна.
- 5.2.3 "E-Mongolia" төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэхэд хотын шаардлагатай бүх цэгт киоск машиныг суурилуулж, төрийн мэдээллийг ил тод болгож, иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг бодитойгоор хэмнэнэ.
- 5.2.4 Хотоос олгогддог бүх төрлийн зөвшөөрлийг цахимжуулах ажлыг үргэлжлүүлж, төрийн үйлчилгээний хурд, чанарыг нэмэгдүүлнэ.





5.2.5 Барилга байгууламж болон инженерийн дэд бүтцийн мэдээллийг нэгтгэж, хот төлөвлөлтийн бичиг баримтын хамт цахимаар ашиглах боломжийг бий болгож, бодлого боловсруулахад ашиглана.


### 5.3 Гамшгийн бэлэн байдал

5.3.1 Онцгой байдлын байгууллагын аюул гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн болон албан хаагчдын чадавхыг сайжруулж, бэлэн байдлыг бэхжүүлнэ.

5.3.2 Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.

5.3.3 Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.

5.3.4 Үерийн далан, ус зайлуулах шугамын өргөтгөл, шинэчлэлтийг хийж, усанд автдаг гэр хорооллын гудамжийн тоог эрс бууруулна.



5 дэд бүлэг 101 заалт



НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 988  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Налайх дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Налайх дүүргийн Монгол ардын намын хорооны Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад шаардлагад тус тус нийцсэн байна.

Налайх дүүргийн Монгол Ардын Намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Налайх дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## АГУУЛГА

Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024-2028 оны  
ээлжит сонгуульд Монгол ардын намаас оролцох мөрийн хөтөлбөр



Уриа: Стандарттай Налайх ХОТ

“Х.О.Т” буюу Хүн төвтэй

Орчин төвтэй

Төлөвлөлт төвтэй бодлого

### 1. ХҮН ТӨВТЭЙ НАЛАЙХ ХОТ

- 1.1 Эрүүл иргэн
- 1.2 Чанартай боловсрол
- 1.3 Өв соёл, урлаг
- 1.4 Спорт, нийтийн биеийн тамир
- 1.5 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- 1.6 Иргэнд чиглэсэн төрийн цахим үйлчилгээ
- 1.7 Иргэдийн оролцоонд суурилсан төрийн үйлчилгээ

### 2. ОРЧИН ТӨВТЭЙ НАЛАЙХ ХОТ

- 2.1 Хөрөнгө оруулалтыг дэмжих
- 2.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
- 2.3 Аялал жуулчлалыг хөгжүүлэх

### 3. ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ НАЛАЙХ ХОТ

- 3.1 Эрчим хүч, дулаан хангамжийн төлөвлөлт
- 3.2 Барилга байгууламж, инженер хангамжийн төлөвлөлт
- 3.3 Хүрээлэн буй орчны төлөвлөлт



НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024-2028 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



**Уриа: Стандарттай Налайх ХОТ**

**НЭГ. ХҮН ТӨВТЭЙ НАЛАЙХ ХОТ**

**1.1 Эрүүл иргэн**

1.1.1 Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийг орчин үеийн стандартад нийцсэн тоног төхөөрөмж бүхий бүсийн оношлогооны төвийн төвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх Налайх хотын 300 ортой нэгдсэн эмнэлгийг шинээр барина.

1.1.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээнд чанар хүртээмж, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эмчилгээ, оношлогооны нэр төрлийг нэмэгдүүлнэ.

1.1.3 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг 2 жилээр ойртуулах бодлого баримтална.

1.1.4 Шүд, амны хөндийн эрүүл ахуйн хөтөлбөр хэрэгжүүлж, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, халдварт бус өвчлөлийг бууруулах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.5 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийг жил бүр зохион байгуулж, иргэдийг бүрэн хамруулах бодлого баримтална.

1.1.6 Дүүргийн эрүүл мэндийн төвд адитлоги /донтолт/-ийн тасаг байгуулна.

1.1.7 Дүүргийн эрүүл мэндийн төвд Эрэгтэйчүүдийн тасаг байгуулна.

**1.2 Чанартай боловсрол**

1.2.1 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсрол /цэцэрлэг/-д хамруулж, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд байлгана.

1.2.2 Ерөнхий боловсролын сургуулийг шинээр барьж байгуулах, өргөтгөх замаар хүчин чадлыг жил бүр нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд байлгана.

1.2.3 Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг өргөтгөж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүх шатны боловсролд тэгш хамруулах, зайны сургалтыг нэмэгдүүлэн, төгсөгчдийг дараагийн шатны сургалт дадлага, ажлын байранд зуучлах үе шаттай тогтолцоог бий болгоно.

1.2.4 Налайх хотын онцлогт тохируулан багшлах хүний нөөц, хүүхдийн хөгжил, соёлч эрүүл зөв дадал, эерэг хандлагатай иргэн болгож төлөвшүүлэх зорилгоор "Налайхын боловсрол – 2024-2028" хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ.

1.2.5 Сургууль, цэцэрлэг, Насан туршийн суралцахуйн төвд суралцаж буй хүүхдүүдийн хоолны стандарт, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, стандартыг мөрдүүлнэ.

1.2.6 Нэгээс доошгүй ерөнхий боловсролын сургуулийг олон улсын Кембрижийн хөтөлбөрт шилжүүлнэ.

1.2.7 Боардинг сургууль, лицей сургууль байгуулахыг дэмжиж, олон улсын нэр хүндтэй их сургуулиудад тэтгэлэгээр элсэх нөхцлийг нэмэгдүүлнэ.

1.2.8 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сурагчдын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**1.3 Өв соёл, урлаг**



1.3.1 Соёлын ордны 850 хүний суудал бүхий шинэ барилгыг барьж, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, орчин үеийн шаардлагад нийцсэн кино театр бүхий энтертайнмэнт төвийг байгуулна.

1.3.2 Налайхын Соёлын ордны үйл ажиллагааг чуулга, театр болгон өргөтгөж, ажиллах хүний нөөц, материаллаг баазаар бүрэн хангана.

1.3.3 Налайхын Их уурхайн дурсгалт газар, аялал жуулчлал ногоон байгууламж бүхий амралт чөлөөт цаг өнгөрүүлэх төв, музей байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.3.4 Иргэдийн соёлын хандлагыг төлөвшүүлэх, хотын соёлыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.3.5 “Бүс нуур” цогцолборт уламжлалт соёл, ёс заншлыг таниулах цогцолборыг байгуулна.

1.3.6 Казак үндэстний өв соёлыг сурталчилах төвийг шинээр байгуулна.

1.3.7 Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх соёл амралтын хүрээлэн /хүүхдийн парк/-г төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

#### **1.4 Спорт, нийтийн биеийн тамир**

1.4.1 Бүх насны иргэдийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, стандартад нийцсэн спорт заал, танхимын тоог нэмэгдүүлнэ.

1.4.2 Иргэд, олон нийтийг биеийн тамир, спортоор хичээллэх орчныг бүрдүүлж, дүүргийн, улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулна.

1.4.3 Улс, тив, дэлхий, олимпийн наадамд оролцох тамирчдын өрсөлдөх боломжийг нэмэгдүүлж, тэднийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.4 Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.

1.4.5 “Шинэ налайх” цэцэрлэгт хүрээлэнд хөлбөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөг, талбайн теннис зэрэг спортын гадна талбайтай болгоно.

1.4.6 Хүүхдийн тоглоомын талбайгүй хэсгүүдийг бүрэн тоглоомын талбайтай болгож, хүүхдийн насны онцлогт тохирсон байдлаар тоглоомын талбайг MNS 6751:2019, UCS 1405B:2022 стандартад нийцүүлэн тохижуулна.

#### **1.5 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал**


1.5.1 Эдийн засгийн тусгай бүс болж байгаа тул жил бүр дунджаар 1000 ажлын байрыг шинээр бий болгоход зорилт тавьж байгаа.

1.5.2 “Шинэ хоршоо” хөтөлбөр, “Бүтээлч залуучууд” зэрэг хөтөлбөр хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.5.3 Хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцүүлэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих төв” ажиллуулна.

1.5.4 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилгоор олон улсын үзэсгэлэн худалдаа бусад улс, хотуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлж ажиллана.

1.5.5 Мэргэжилгүй залуучуудад мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтэд холбон зуучилна.





1.5.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд болон нийгмийн хамгааллыг дэмжих амьдралын чанарыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.5.7 Ахмад настны амралт, сувилалын 60 ортой төвийг байгуулж, байнгын ажиллагаатай болгоно.

1.5.8 Налайх хотын ногоон бүсэд хүүхдийн зуслантай болно.

1.5.9 Хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлсэн хяналтын тогтолцоог нэмэгдүүлж, түр хамгаалах байрны үйл ажиллагааг жигдрүүлнэ.

1.5.10 Эмнэлэг, Засаг даргын Тамгын газар зэрэг иргэд олноор үйлчлүүлдэг газруудын шатыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан нэмж тоноглон автомат шаттай болгоно.

## **1.6 Иргэнд чиглэсэн төрийн цахим үйлчилгээ**

1.6.1 Төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцлийг нэмэгдүүлж, хороо бүрт “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем”-ийг нэвтрүүлнэ.

1.6.2 Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх операторийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.6.3 Иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор авто зам, гудамж, олон нийтийн зам талбайг бүрэн камержуулан, хяналтын цогц шийдлийг нэвтрүүлж, Налайх хотыг “аюулгүй бүс” болгоно.

1.6.4 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж, хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

## **1.7 Иргэдийн оролцоог дэмжсэн төрийн үйлчилгээ**

1.7.1 Засаг даргын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийн саналд үндэслэж батална.

1.7.2 Гамшигийн эрсдлийг бууруулахад иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлнэ.

1.7.3 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйлчилгээг үе шаттайгаар хувийн хэвшилд шилжүүлэх замаар өрсөлдөөнийг бий болгоно.

1.7.4 Налайх хотын өмчийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх менежментийг хэрэгжүүлнэ.

1.7.5 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлж, “шилэн” болгоно.


1.7.6 Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүй, хандлагыг эрс шинэчилэн, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэхээр суралцуулах, солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## **ХОЁР. ОРЧИН ТӨВТЭЙ НАЛАЙХ ХОТ**

### **2.1 Хөрөнгө оруулалтыг дэмжих**

2.1.1 Налайх дүүргийг төсвийн орлогоо бүрэн бүрдүүлдэг бие даасан хот болгон хөгжүүлнэ.

2.1.2 Дүүргийн нутаг дэвсгэрт “Эдийн засгийн тусгай бүс” байгуулан бизнес эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлнэ.



2.1.3 Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийг бүрэн ажиллагаанд оруулахад шаардагдах дэд бүтцийг шийдвэрлэж, 50-иас доошгүй үйлдвэр, 1500-аас доошгүй ажлын байрыг бий болгохыг зорилт тавьж байгаа.

2.1.4 Суурьшлийн бүс бүхий олон улсын жишигт нийцсэн тээвэр логистикийн бие даасан бүсийг байгуулна.

2.1.5 “Налайхад хөрөнгө оруулагчдын форум”-ыг тогтмол зохион байгуулж, бизнес эрхлэх, хөрөнгө оруулах нөхцлийг бүх талаар дэмжинэ.

2.1.6 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт олон улсын стандартад нийцсэн мах боловсруулах үйлдвэрлэл, лаборатори бүхий каластрыг байгуулна.

2.1.7 Бизнес эрхлэх, инновацийг хөгжүүлэх “Nalaikh innovation Hub” төвийг байгуулна.

## **2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих**

2.2.1 “Хамтдаа хөгжинө, Налайхад үйлдвэрлэв” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.2 Эрчимжсэн мал аж ахуй, хүнс хөдөө аж ахуйн чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.

2.2.3 Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллана.

2.2.4 Хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий стандартад нийцсэн нийт 1000 тн багтаамж бүхий зоорь барихад дэмжлэг үзүүлэн ажиллана.

2.2.4 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийг нэмж байгуулна.

2.2.5 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## **2.3 Аялал жуулчлалыг дэмжих**

2.3.1 Аялал жуулчлалын маршрутыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

2.3.2 Гадаад, дотоодын жуулчдад “Nalaikh city tour” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.3 “Нүүдэлчин Монгол” соёлын фестиваль, “Плэй тайм” олон улсын хөгжмийн наадмыг тогтмол зохион байгуулж, холбогдох дэд бүтцийг шийдвэрлэнэ.

2.3.4 Туул, Тэрэлж голын эрэг дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр амрах цэгүүдийг байгуулна.

2.3.5 Мэргэн тоньюкукийн гэрэлт хөшөө цогцолбор бүхий музейг байгуулж, гадаад, дотоодын жуулчдын хүртээл болгоно.

## **ГУРАВ. ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ НАЛАЙХ ХОТ**

### **3.1 Эрчим хүч болон дулаан хангамжийн төлөвлөлт**

3.1.1 Налайх хотын 2040 он хүртэлх ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.2 Налайх хотод 270 МВт чадалтай дулааны шинэ станцын үүсгүүрийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.1.3 Налайхын дулааны станц ТӨХК-ийн цэвэр усны хос шугамтай болгоно.



3.1.4 Налайх хотын төвд болон 5 дугаар хороонд эрчим хүчний нэмэлт шинэ дэд станцуудыг байгуулж, дүүргийн иргэд, аж ахуйн нэгжийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрийн чадлыг нэмэгдүүлнэ.

3.1.5 1-р хорооны Энгэршанд, Их ам /зуслангийн бүс/, 3-р хорооны малчид бүхий суурьшлийн бүс, 4-р хорооны Бүс нуур, Их ам, 5-р хорооны Элстэй, Бүс нуур, Гандан-Ам, 6-р хорооны Шилжрээ зэрэг шинэ суурьшлын бүс, хүчдэлийн уналттай айл өрхийн эрчим хүчний асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх.

3.1.6 Хог ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулж, дулаан болон эрчим хүч гаргах ажлыг эхлүүлнэ.

3.1.7 Уурхайн зориулалтаар ашиглаж байсан газраас 150 га газарт сэргээгдэх эрчим хүчний станц байгуулна.

3.1.8 5-р хорооны магистрал шугамыг шинэчлэн татаж, ус дулаан дамжуулах төв /ЦТП/-ийг шинээр барина.

## **3.2 Барилга байгууламж болон инженер хангамжийн төлөвлөлт**

3.2.1 Барилга байгууламжийн стандарт норм, дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллана.

3.2.2 Налайх хотын цэвэр усны төв шугамыг хос эх үүсвэртэй болгох.

3.2.3 5-р хорооны Гандан-Уул, 1-р хорооны Энгэршанд, 4-р хорооны Нисэх, 8-р хорооны Нарлаг, Тайж, 6-р хорооны Шилжрээ, Мэлхий хад, Болор зэрэг гэр хорооллын дундах авто замыг өргөтгөх, шинэчлэх, шинээр байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.4 Налайх-Тэрэлж чиглэлийн 34км автозамыг 4 эгнээ болгон өргтгөнө.

3.2.5 Нийтийн тээврийн парк шинэчлэлийг бага, дунд, их оврын автобусаар шийдвэрлэж, дотор шугамын маршрутыг нэмэгдүүлж, автобусны зогсоол, буудлыг стандартад нийцүүлж хийнэ.

3.2.6 Орон сууцны айл өрхийн насжилт өндөртэй цэвэр усны 8 км шугамыг шинэчлэх, зэс хоолойтой болох ажлыг эхлүүлэх, вулкан зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлж, зэвтэй ус хэрэглэх байдлыг таслан зогсооно.

3.2.7 1-р хорооны Баянзүрх, Уурхайчид, 5-р хорооны Гандан-Уул, 7-р хорооны Бадрал, Өвөршанд хэсэг, 3, 4 дугаар хорооны гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.


3.2.8 2-р хорооны 35-39, 5-р хорооны 78, 80 зэрэг байрны гадна дулаалга /пасад/-ыг хийж, дулаан алдагдлыг арилгана.

3.2.9 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууц болох нийтийн цагаан байрууд, Нарлаг, Тайж, Бадрал, Өвөршанд хэсэг, 3, 4-р хороонд гэр хорооллыг дахин төлөвлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2.10 Налайх хотод шинээр 5000 айлын орон сууц барих бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2.11 Гэр хорооллын иргэдийн ундны усны үнийг 2 дахин бууруулж, ус түгээх цэг /худаг/-ийг бүрэн ухаалаг системд холбоно. Ус тээвэрлэх автомашины парк шинэчлэлийг 100% шийдвэрлэнэ.

3.2.12 Налайх хотын хэмжээнд стандартад нийцсэн 11,5 км үерийн байгууламжийг цогцоор барьж байгуулна.



3.2.13 Дүүргийн төвлөрсөн хогийн цэгийг ногоон байгууламж бүхий хашаатай болгоно.

3.2.14 Дүүргийн авто замыг бүрэн ус зайлуулах системтэй болгоно.

3.2.15 Гэр хорооллын гудамжийг байгалийн чулуун замтай болгох ажлыг үе шаттай эхлүүлнэ.

### 3.3 Хүрээлэн буй орчны төлөвлөлт

3.3.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд болон уул уурхайн ашиглалтаас орхигдсон газарт нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг 70-аас доошгүй хувиар бууруулна.

3.3.2 БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран 8-р хорооны Нарлаг хэсэгт уурхайн зориулалтаар ашиглаж байсан 10 га газрыг иж бүрэн нөхөн сэргээлт хийж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

3.3.3 Тоосго, төмөр, цементний үйлдвэрийн тоосжилт, дуу чимээг багасгах, технологийг сайжруулах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг дэмжин ажиллана.

3.3.4 Тоосго, төмөр, цементний үйлдвэрт гүний ус ашиглахыг хязгаарлаж, хэрэглэсэн усыг дахин ашиглах саарал усны технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.

3.3.5 Авто угаалгын газруудад хэрэглэсэн усыг дахин ашиглах саарал усны технологийг нэвтрүүлнэ.

3.3.6 “Эко Налайх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах ажлыг эрчимтэй хэрэгжүүлнэ.

3.3.7 Гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, хөрсний бохирдол үүсгэдэггүй технологийг нэвтрүүлнэ.

3.3.8 “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг туштай дэмжиж, агаарын бохирдлыг бууруулах, амьдрах таатай орчин бүрдүүлэх зорилгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллана. Дүүрэг хороололд бичил цэцэрлэг байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ.

3.3.9 Гэр хорооллын өрх бүрийг мод тарьж, ургуулах хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.

3.3.10 Явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх үүднээс явган болон дугуйн замыг 2 дахин нэмэгдүүлнэ.

3.3.11 Налайхаас Тэрэлж, Цонжин болдог чиглэлийн авто зам дагуу мод тарих “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3.12 Гэр хорооллын иргэдийн хог ачилтыг 14 хоног болгон үйлчилгээг 2 дахин нэмэгдүүлнэ.

3.3.13 1-р хорооны Энгэршандад гадаргын ус хурилтлуулах сан байгуулж, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах технологийг нэвтрүүлнэ.

3.3.14 Оршуулгын газрын хэмжээг хязгаарлаж, олон улсын стандартад нийцсэн чандарлах байгууламжийг хувийн хэвшилтэй хамтран барьж байгуулна.

НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 980

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Багахангай дүүргийн Монгол ардын нам хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Багахангай дүүргийн Монгол ардын намын хорооны Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багахангай дүүргийн Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Багахангай дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн Монгол Ардын Намын хорооны гуравдугаар хуралдааны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн тогтоолын хавсралт



### ЭРХЭМ СОНГОГЧ ТАНАА:

Өнөөгийн Багахангайчууд бидэнд дүүргийн эдийн засгийн хөгжлийг түүчээлэн үргэлжлүүлэх хүндтэй, хариуцлагатай үүрэг ноогдож байна.

Дүүргийн Монгол Ардын Намын хороо Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохдоо хүнээ дээдлэх үзэлд суурилсан “Шинэ сэргэлт-Багахангай” мөрийн хөтөлбөртөө ирэх 4 жилд хийж бүтээх бодлого, зорилтоо тусган сонгогч Та бүхэндээ толилуулж байна.

Багахангай дүүргийн Монгол Ардын намаас Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийг сонгох 2024 оны ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийн Алсын хараа:

- Эрүүл боловсролтой иргэн
- Бизнесийн таатай орчин бүрдсэн үйлдвэржсэн бүс
- Цахим хөгжил, нээлттэй засаглал
- Стандарт хангасан Эко дүүрэг
- Амьдрах орчин сайжирсан, орон сууцтай иргэн

### НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### Эрүүл мэнд

1.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл зөв амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

1.1.1. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, нарийн мэргэжлээр сурган дадлагажуулж, боловсон хүчнийг нэмэгдүүлнэ.

1.1.2. Эрүүл мэндийн төвийг оношилгоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.


1.1.3. Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, оношилгоо эмчилгээг сайжруулна.

1.1.4. Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан, “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.5. Хүн амд үзүүлэх явуулын үйлчилгээг хөгжүүлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд цахим технологийн хэрэглээг өргөжүүлнэ.

1.1.6. Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүссэн өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшилд сургана.

1.1.7. Эмийн сангийн үйл ажиллагаа, чанар хүртээмжийг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.



**Биеийн тамир**

**1.2. Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.**

1.2.1. Дүүрэгт улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан болон нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.2.2. Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, улс, нийслэл, бүсийн тэмцээнд оролцуулан, дэмжлэг үзүүлнэ.

1.2.3. 2 дугаар хорооны “Спорт цогцолбор”-ын барилгыг ашиглалтад оруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр үе шаттай хангана.

1.2.4. “Усан спорт сургалтын төв”-ийн барилгын төсвийг холбогдох дээд шатны байгууллагад уламжилна.

1.2.5. Хүүхэд багачуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, уралдаан тэмцээнд амжилттай оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд 3х3 сагсан бөмбөгийн талбайг нэмэгдүүлнэ.

**Боловсрол**

**1.3. Хүн бүрт чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.**

1.3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барьж байгуулан, стандартад нийцүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.2. Багш нарыг мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулна.

1.3.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.

1.3.4. Ээлжийн ажилтай иргэд, алслагдсан өртөө зөрлөг, малчин өрхийн хүүхдүүдийг ая тухтай сурч боловсроход дэмжлэг үзүүлэн хүүхэд харах үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, сургуулийг дотуур байртай болгоно.

1.3.5. Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) хүүхдийн үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах боломжийг бүрдүүлэн, сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлж, дэд бүтцийн орчныг сайжруулна.

1.3.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр хангаж, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, нийтийн хоолны үндсэн шаардлага, стандартыг мөрдүүлэн, “Сүү”, “Үдийн хоол” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сургуулийн цайны газрыг бие даасан хэлбэрээр ажиллуулна.


1.3.7. “Насан туршийн суралцахуйн төв”-ийг байгуулж, хүн бүр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.

**Нийгмийн халамж**

**1.4. Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.**

1.4.1. Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн, амьдралын чанарыг сайжруулна.

1.4.2. Иргэдийн нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.



*[Handwritten signature]*





1.4.3. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Хөдөлмөр эрхлэлт**

**1.5. Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.**

1.5.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.2. Багахангайн үйлдвэрлэл технологийн паркаар дамжуулан ажлын байрыг нэмэгдүүлж ажиллана.

1.5.3. Мэргэжлийн ур чадвар олгох сургалт болон төсөл хөтөлбөрт хамрагдах сургалтад иргэдийг хамруулан чадавхжуулж, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

1.5.4. Эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучуудын талаарх төрөөс баримтлах бодлогыг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

**Соёл урлаг**

**1.6. Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулан, мэргэжлийн байгууллагатай хамтарч соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулна.**

1.6.1. 500 хүний суудалтай Соёлын ордны барилгыг ашиглалтад оруулж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.6.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, уламжлуулах, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулна.

1.6.3. Соёлын ордныг орчин үеийн стандартын шаардлага хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.

1.6.4. Иргэд олон нийтийн дунд хотын соёлыг дээшлүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

**Гэр бүл, хүүхэд, залуучууд**

**1.7. Гэр бүлд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээг сайжруулна.**

1.7.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн байрыг ашиглалтад оруулж, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.7.2. Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүүхэд хамгааллын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.7.3. Залуучуудын сурч боловсрох, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэн, залуу гэр бүлийг дэмжинэ.

1.7.4. Дүүргийн "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

1.7.5 Соёлын ордны хуучин барилгыг засварлан хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх, сурч хөгжих боломжийг хангасан "Хүний хөгжлийн төв" байгуулна.

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**  
**Санхүү, төсвийн зохицуулалт**



**Зорилт 2.1. Нийслэл, дүүргийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна.**

2.1.1. Нийслэл дүүргийн татварын орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж зарцуулах дотоод хяналтыг сайжруулна.

2.1.2. Нийслэл, дүүргийн өмчийг иргэн аж ахуйн нэгжүүдэд түрээслэх, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлнэ.

2.1.3. Орон нутгийн хөгжлийн санд иргэдийн саналыг тусган үр дүнтэй зарцуулж, иргэдэд нээлттэй ил тод мэдээллэх, иргэдийн оролцоо хяналтыг сайжруулна.

2.1.4. Нийслэл, дүүргийн татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, татвар ноогдуулах, хураах үйл ажиллагааг цахимжуулна.

2.1.5. Орон сууц барьсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх бодлого баримтална.

2.1.6. Төсөвт байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

**Зорилт 2.2. Бизнесийн орчин буюу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, бичил жижиг дунд үйлдвэрийг дэмжих, гадаад дотоодын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж ажлын байрыг олноор бий болгоно.**

2.2.1. Дэд бүтцийн тааламжтай нөхцөлийг түшиглэн худалдаа-бизнес, хүнсний болон хөнгөн үйлдвэр, ачаа тээврийн логистикийн төвийг байгуулна.

2.2.2. Үйлдвэрлэл-Инноваци төв байгуулж, хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлт, гарааны бизнесийг дэмжинэ.

2.2.3. Жижиг дунд, бичил бизнес эрхлэгчдийг зээл тусламжид хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, бизнесийн дэмжлэг үзүүлнэ.

2.2.4. Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцуулах замаар борлуулалтын сувгийг өргөжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.2.5. "Багахангайн үйлдвэрлэл технологийн парк"-ийн дэд бүтэц бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлж хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлэн, шинээр ажлын байрыг бий болгоно.

**Хүнс, хөдөө аж ахуй**

**Зорилт-2.3. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, мал сүргийг эрүүлжүүлэх**

2.3.1. Хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэр, жижиг дунд үйлдвэрт кластеруудын төвийг байгуулахыг дэмжих;

2.3.2. Малыг эрүүлжүүлэх, чанар, үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж малчдыг нэгтгэн "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг өрнүүлэх

2.3.3 Мал амьтныг халдварт болон шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулна.

1177148533  
1177148533



2.3.4 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, иргэдэд эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдан борлуулах сувгийг нэмэгдүүлнэ.

### **Аялал жуулчлал**

**Зорилт 2.4.Орон нутгийн брэнд, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.**

2.4.1.Дүүрэгт худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг байгуулна.

2.4.2.Чингис хаан үндэсний музейтэй хамтран монгол ёс заншлыг сурталчлах хүүхдийн нүүдлийн соёлын боловсролын зуслан байгуулна.

2.4.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй хослуулан монгол ахуйн соёл, морин болон явган аялал, өвлийн аялалыг хөгжүүлнэ

2.4.4 Багахангай дүүрэгт “Нар харах” үйл ажиллагааг өргөжүүлэн, аялал зуучлалын бүтээгдэхүүн болгож хөгжүүлнэ

### **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**Зорилт 3.1. Иргэн төвтэй, цахимжсан үйлчилгээг нэвтрүүлсэн ил тод, нээлттэй дүүрэг болно.**

3.1.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулна.

3.1.2. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлэн, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

3.1.3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана.

3.1.4.Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад үе шаттай хамруулна.

3.1.5. Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.

3.1.6. Дүүргийн гадаад хамтын харилцааг өргөжүүлэн, гадаад улс орон, хотуудтай харилцаа тогтоож, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

3.1.7. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан “Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.1.8.“Шуурхай удирдлагын төв”-ийг 2 дугаар хороонд шинээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.

**Зорилт 3.2.Иргэдийг амар тайван, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлж, ногоон бүс болгоно.**

3.2.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, олон нийтэд түшиглэсэн сайн дурын байгууллагуудыг дэмжиж ажиллана.

3.2.2.Дүүргийн камержуулалтын системийг иж бүрнээр шинэчлэн “Шуурхай удирдлагын төв”-д шилжүүлэн холбоно.

3.2.3.Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний зөрчлөөс урьдчилан сэргийлж, авто замын уулзвар гарцыг өргөтгөн, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлнэ.

3.2.4.Тусгай чиг үүргийн байгууллагуудын дадлага, сургалтын цогцолборыг барьж байгуулна.

УХА0612 9077278



3.2.5. Дүүргийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хороод тус бүрээр хийнэ.

3.2.6. Дүүргийн барилга байгууламжуудад газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээг хийлгэж паспортжуулна.

3.2.7. Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах арга хэлбэрүүдийг өргөжүүлэн иргэдэд хууль эрх зүйн мэдээ мэдээлэл, Цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчлах ажлыг тогтмолжуулж иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ.

3.2.8. Өсвөр насны хүүхэд багачуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дээшлүүлэх ажлыг дүүрэг орон нутгийн хэмжээнд холбогдох байгуулагуудтай хамтран зохион байгуулна.

## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### Ногоон байгууламж

**Зорилт 4.1. Дүүрэгт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх оновчтой менежментийг нэвтрүүлэн, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.**

4.1.1. "Тэрбум мод" аяны хүрээнд мод үржүүлгийн газрыг байгуулна.

4.1.2. Бичил цэцэрлэгүүдийг нэмэгдүүлж, "Өрх бүр-Нэг мод" аяныг өрнүүлнэ.

4.1.3. Дүүргийн иргэдийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлэн дэмжлэг үзүүлнэ.

4.1.4. Багахангай өндөрлөгийг тохижуулж, 30 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулан, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх ая тухтай орчинг бий болгоно.

4.1.5. "Өндөртолгой уул"-ыг тохижуулан, гэрэлтүүлэг, ногоон байгууламж бүхий орчныг бүрдүүлнэ.

4.1.6. Дүүргийн хэмжээнд шаардлагатай газруудад нөхөн сэргээлт хийнэ.

**Зорилт 4.2. Иргэдийн амьдрах орчныг сайжруулан, орчны стандарт, аюулгүй байдлыг хангана.**

4.2.1. Хүүхдийн тоглоомын талбайн орчны стандартыг мөрдүүлэн хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

4.2.2. Дүүргийн төвлөрсөн хогийн цэгийг дарж булшлан, орчин үеийн технологи бүхий шинэ хогийн цэгийг бий болгоно.

4.2.3. Усны шинэ эх үүсвэрийг тусгай хамгаалалтад авч хашаажуулна.

4.2.4. Бэлчээрийн доройтлыг арилгах, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, цөлжилттэй тэмцэх ажлуудыг зохион байгуулна.

## ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### Дэд бүтэц, бүтээн байгуулалт

**Зорилт 5.1. Дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийг орон сууцжуулах замаар амьдрах орчныг сайжруулна.**

5.1.1. Төр, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр иргэдийг орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

5.1.2. Нуур, Замчин гэр хорооллын "Дэд бүтцийн төв"-ийн гадна инженерийн хангамж, шугамын ажлыг үргэлжлүүлнэ.

5.1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн явган хүний замыг засаж сайжруулна.

5.1.4. Шинэ суурьшлын бүсүүдийн цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг өргөтгөн сайжруулна.

5.1.5. Дүүргийн гол болон туслах авто замын засвар, шинэчлэлтийг хийж шинээр зам барьж байгуулна.

1117148633  
1117148633



5.1.6. Үерийн хамгаалалтын далан суваг, зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөж, шинэчлэн хийнэ.

5.1.7. Баяр наадмыг зохион байгуулах талбайг барьж байгуулна.

5.1.8. 1 дүгээр хорооны хойд жигүүрийн халаалт, хэрэглээний болон цэвэр усны шугамыг шинэчилнэ.

5.1.9. "Илч-Орд" ОНӨААТҮГ-ын халаалтын зуухыг зөөж шилжүүлнэ.

5.1.10. Дүүргийн 1 дүгээр хорооны нийтийн зориулалттай орон сууцны 2, 3, 4, 5, 6 дугаар байрны хэрэглээний халуун ус болон цэвэр усны босоо шугамыг солино.

5.1.11. "Илч-Орд" ОНӨААТҮГ-ын халаалтын зуухны яндангуудад утааны шүүлтүүр суурилуулна.

**Газрын харилцаа**

**Зорилт 5.2. Иргэдийн эзэмшиж буй газрыг өмчлүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах бодит нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.**

5.2.1. Дүүрэг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулна.

5.2.2. Дүүрэгт газар эзэмших, ашиглах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж, төсөвт орлого төвлөрүүлнэ.

5.2.3. Дүүргийн нутаг дэвсгэр дэх зэвсэгт хүчний жанжин штабын мэдэлд байгаа газруудыг дүүргийн өмчид шилжүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилж, хууль журмын хүрээнд иргэний зориулалтаар ашиглуулна.

**Монгол Ардын Намаас нэр дэвшигчдэд итгэл хүлээлгэн дүүрэг орон нутгийнхаа хөгжил, цэцэглэлтийн төлөө хамтдаа зүтгэцгээе.**

